

ТАУС!

Төрийн Агуулгын Удирдлагын Систем, 1.0.х-р хувилбар

Администратор, зохицуулагчийн гарын авлага

ТАУС! Администратор, зохицуулагчийн гарын авлага

Агуулга:

1.0 Удиртгал

- 1.1 Веб сайтдаа нэвтрэх нь
- 1.2 Нэвтрэх

2.0 ТАУС-ын удирдах самбар

- 2.1 Веб сайтынхаа зарим бичлэгтэй танилцах нь, тэд нь ТАУС-д ямар хэрэгтэй вэ?
- 2.2 Статик материал нэмэх, үндсэн цэсийн холбоос үүсгэх
- 2.3 Оруулсан статик материал руугаа хандсан холбоос үндсэн цэст үүсгэх
- 2.4 Цэсийн элементүүдэд зориулан дэд-холбоос үүсгэх нь

3.0 Секц (sections), Категори (categories), Бичлэгүүдийн (items) талаар

- 3.1 Секц үүсгэх, засварлах
- 3.2 Категори үүсгэх, засварлах
- 3.3 Категори дотор бичлэг үүсгэх, түүнийг засварлах

4.0 Шинээр нэмэгдсэн мэдээний модуль хэрхэн ажилладаг вэ?

- 4.1 Мэдээний шинэ модулийн тохиргоог хийх: Деталь, Параметр, Хуудасны тохиргоо

5.0 Нvvp хуудасны компонентийн тухай

- 5.1 Нvvp хуудасны компонентийн тохиргоог хийх
- 5.2 Нvvp хуудасны компонент рvв хандсан холбоос vvcгэх
- 5.3 Нvvp хуудасны компонентийн цэсийн элементийн (холбоос) тохиргоог хийх
- 5.4 Нvvp хуудасны компонентд хандсан холбоосын тохиргоог хийх

6.0 Санал асуулгын компонент, модулийг ашиглан хэрэглэгчийн асуулга хийх

- 6.1 Веб дээрээ санал асуулга идэвхжvвлэх
- 6.2 Санал асуулгын модулийн веб дээрх байршлыг тохируулах
- 6.3 Модулийн тохиргоог еерчлэх - Деталь, хуудасны тохиргоо г.м

7.0 Шинэ хэрэглэгч нэмэх

- 7.1 Сайтын хэрэглэгчийн тохиргоог еерчлэх
- 7.2 Хэрэглэгч устгах

8.0 Зураг нэмэх - Медиа менежерийг хэрхэн ашиглах тухай

- 8.1 Медиа менежерт файл хуулж оруулах
- 8.2 Файлуудаа эмх цэгцтэй байлгахын тулд фолдер vvcгэх нь
- 8.3 Веб хуудсанд зураг буюу баримт оруулах

9.0 Глобал тохиргоо

- 9.1 “Site” тохиргооны бүлэг:
- 9.2 “Locale” тохиргооны бүлэг:
- 9.3 “Content” тохиргооны бүлэг:
- 9.4 “Database” тохиргооны бүлэг:
- 9.5 “Server” тохиргооны бүлэг:
- 9.6 “Metadata” Тохиргооны бүлэг:
- 9.7 “Mail” Тохиргооны бүлэг:
- 9.8 “Cache” Тохиргооны бүлэг:
- 9.9 “Statistics” Тохиргооны бүлэг:
- 9.10 “SEO” Тохиргооны бүлэг:

10.0 Вебсайт харах, Сайтын статистик

- 10.1 Вебсайт харах
- 10.2 Сайтын статистик

11.0 Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

- 11.1 Сайтын загвар
- 11.2 Устгагдсан агуулгууд

12.0 Зөвлөгөө

1.1 Удиртгал

ТАУС Агуулгын удирдлагын систем (ТАУС!)-ыг ашигласнаар HTML ч юмуу, өөр ямар нэгэн программчлалын хэлний мэдлэггүй энгийн хүн, та бид хамгийн хялбараар өөрийн гэсэн веб сайтай болж, түүнийгээ шинэчлэн сайжруулж, шинэ шинэ материал нэмэн, хуучирсан заримыг нь устгах боломжтой болно.

ТАУС!-ын цаана ажиллаж байгаа программ нь таны оруулсан мэдээллийг вебийн программчлалын хэлрүү өөрөө хувиргах учир таны веб хамгийн бага хүчин чармайлтаар байнга шинэчлэгдэж байх боломжтой. Адил төстэй ТАУС-уудын хүчин чадал нь янз янз боловч гол төлөв веб хуудас хийх, загвар дизайныг нь янзлах, агуулгыг нь индекслэж дотроос нь хэрэглэгч юм хайх боломж олгох гэх мэт үндсэн функцуудтай байдаг юм.

ТАУС! нь харин маш олон төрлийн функц, модуль, нэмэлт хэрэгслүүдийг агуулсаныг та доороос харж болно:

- Веб хуудасдаа цэс үүсгэж, текст, зураг аль аль нь орсон байдлаар хийх боломжтой
- Шинэ мэдээний секц нэмэх
- Мэдээ автоматаар татаж оруулах механизм нэмэх
- Хэрэглэгчдийн дунд санал асуулга явуулах
- Зочиддоо санал солилцох форум (хэлэлцүүлэг ч гэдэг) нэмж өгөх
- Зөвхөн бүртгүүлсэн хэрэглэгчид нэвтрэх боломжтой хамгаалагдсан “бүс” нэмэх
- Документ татаж авах боломжтыг хэрэглэгчиддээ олгох г.м

Хэрвээ та баримт бичиг боловсруулдаг textpad, MS Word зэргийг ашиглаж чаддаг бол ТАУС!-ыг ашиглаж чадна. Одооноос веб хуудас хийхэд ямар ч программчлалын мэдлэг хэрэггүй болсон! Энэхүү заавраас та хэрэгтэй мэдээллээ бүрэн олж чадахгүй бол <http://forum.joomla.org/> хаягаар зочилон ТАУС-ын бусад олон мянган хэрэглэгчидээс асуугаарай.


1.1 Веб сайтдаа нэвтрэх нь

Анхлан суулгасны дараа танд хоёр янзын хаяг өгөгдөх болно: нэг нь веб сайтны тань хаяг, нөгөө нь Агуулгын удирдлагын Системийн (ТАУС!) хаяг.

Ажиллах явцдаа та хоёр браузерийн цонх нээгээд нэгд нь веб сайтаа, нөгөөд нь ТАУС!-аа ачаалвал амар байх болов уу. Ингэснээр өөрийн хийсэн өөрчлөлтүүдээ цаг тухайд нь веб дээрээ шалгах боломжтой болох юм.

ТАУС!-даа нэвтрэхийн тулд та өөрт тань өгөгдсөн хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглах шаардлагатай.


1.2 Нэвтрэх



Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

2.0 ТАУС-ын Удирдах самбар (Control Panel)

Нүүр хуудсан дээрх УДИРДАХ САМБАР нь вебсайт, нэмэлт хэрэгслүүдийн удирдлага, байнга хэрэглэгддэг удирдлагын командууд, шинэчлэгдсэн админы статистик зэрэгт хандсан холбоосуудыг агуулна.



1. Дээд түвшний цэс (top level menus)
2. Файлын хаяг (File Path - таны байгаа хаяг гэсэн үг)
3. Түргэн холбоосын зурагнууд (Quick link icons)
4. Түргэн холбоосын бүлгүүд (Quick link tabs)
5. Жишээ нь энэхүү идэвхтэй байгаа түргэн холбоосны бүлэгт одоо нэвтэрсэн байгаа хэрэглэгчдийн жагсаалт, мөн хамгийн олон шинэчлэгдсэн бичлэгүүд болон хамгийн сүүлд үүсгэгдсэн бичлэгүүдийн жагсаалт, түүнчлэн нэвтэрсэн хэрэглэгчдийг сайтнаас гаргах удирдлага байгааг харж болно.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**2.1 Веб сайтынхаа зарим бичлэгтэй танилцах нь, тэд нь юунд хэрэгтэй вэ?**

Вебсайт бүхэн өөрийн загвар дизайн, хэрэглэх зориулалтаараа дахин давтагдашгүй ялгаатай байдаг. ТАУС-аар хийсэн сайтаа та хамгийн энгийнээс авахуулаад маш нарийн хийцтэй хүртэл олон мянган янзаар хийх өргөн боломжтой бөгөөд хичнээн нарийн төвөгтэй сайт хийлээ ч хяналт хэзээд таны гарт байх болно.

Таны вебсайтын бүх бие даасан бичлэг ТАУС! дотор өөрийн гэсэн функцээр зохицуулагдаж байдаг.

Тодорхой дизайнд зориулагдсан *ВЕБИЙН ЗАГВАР* гэсэн зүйл бий - энэ нь вебэд ямар төрлийн фонт хэрэглэгдэх, олон янзын цэсүүд хаана хаана гарах ёстой, модулиуд (өдрийн мэдээ гэх зэрэг) хаана хаана гарах, сайт нь гурван баганатай байх уу (доорх жишээн дээрх шиг) эсвэл 2, 4, 5 баганатай байх уу гэх мэт зүйлсийг шийддэг юм.


Доор энэхүү гарын авлагад цаашид жишээ болгон ашиглах веб сайтын нүүр хуудасыг харуулав:

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



ТАУС! доторх **menu > main menu** (вндсэн цэс) командаар гарч ирсэн цэсийн жагсаалт хэрхэн таны нүүр хуудас дээрх зүүн талын вндсэн цэстэй тохирч байгааг үз. Энэ нь мөн **menu > topmenu** (толгойн цэс) ба нүүр хуудасны толгойн цэс хоёрын хувьд адил байна:

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



Home Site **Menu** Content Components Modules Mambots Installers Messages System Help

Joomla / com_menus


Menu Manager [mainmenu] Max Levels 10 Filter:

#	<input type="checkbox"/>	Menu Item	Published	Reorder	Order	Access	Itemid	Type	CID
1	<input type="checkbox"/>	Нүүр хуудас			1	Public	1	Component - FrontPage	10
2	<input type="checkbox"/>	МАУС-н лиценз			2	Public	6	Link - Static Content	5
3	<input type="checkbox"/>	Мэдээ			3	Public	2	Table - Content Section	1
4	<input type="checkbox"/>	Мэдээллийн самбар			4	Public	9	Blog - Content Section	0
5	<input type="checkbox"/>	Холбоосууд			5	Public	23	Component - Web Links	4
6	<input type="checkbox"/>	Холбоо барих			6	Public	3	Component - Contacts	7
7	<input type="checkbox"/>	Хайлт			7	Public	5	Component - Search	16
8	<input type="checkbox"/>	News Feeds			8	Public	7	Component - News Feeds	12
9	<input type="checkbox"/>	FAQs			9	Public	25	Table - Content Category	7
10	<input type="checkbox"/>	Wrapper			10	Public	8	Wrapper	0

<< Start < Previous 1 Next > End >>
 Display # 30 Results 1 - 10 of 10

Үндсэн цэсийн элементүүд ТАУС дээр ийнхүү харагдана. Та эндээс цэсийн элементүүдээ нэмж хасч, өөрчлөх бүрэн боломжтой.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах




Харин вебсайт дээр таны үндсэн цэс яг ТАУС дээрхтэйгээ ижил агуулгатай боловч таны сонгосон *Вебийн загварын (template - бид энэ талаар дараа дэлгэрэнгүй үзэх болно)* тогтоосон загвараар ийм хэлбэртэй харагдаж байна.


Бусад цэсүүд ч үндсэн цэстэй ялгаагүй ТАУС-ын толгойн цэсний **menu** командаар зохицуулагдаж байдаг.

Доор дахин нэг жишээ болгож вебсайтын толгойн цэс хэрхэн үндсэн цэстэй ямар ч ялгаагүй зохицуулагдаж байгааг харуулав:

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



ТАУС дээр:



Вебсайтан дээр:



ТАУС!-д жагсаалт маягаар гарч ирсэн Top menu командын бичлэгүүд нь веб сайд дээр таны сонгосон Вебийн загварын тогтоосон загвараар дэлгэцийн зүүн дээд талд гарч ирэн харагдаж байна.


Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**2.2 Статик мэдээлэл нэмэх, үндсэн цэсийн холбоос үүсгэх****Эхлэхээсээ өмнө унш:**

Вебэд суурилсан бусад олон хэрэгсэлтэй адилаар та нэг үр дүнд олон замаар хүрч болно. ТАУС! доторх толгойн цэснээс бүх функцэд хандах боломжтойгоос гадна ихээхэн хэрэглэгддэг тодорхой хэдэн функцуудэд зориулсан түргэн холбоосыг нүүр хуудасны УДИРДАХ САМБАР-аас олж болно.

Таны санавал зохих хамгийн чухал зүйл бол, ТАУС! дотор таны оруулсан **вебийн мэдээлэл бүхэн цэсээс салангид байдлаар оршдог** явдал юм. Өсрөөр хэлбэл, нэг ширхэг статик мэдээлэлд хэрэглэгч хэдэн ч цэсийн холбоосоор дамжин хандаж болно гэсэн үг. Нэг үгээр та үүний үр дүнд та ганц статик мэдээлэлдээ хандсан хэдэн ч цэсийн холбоос үүсгэх боломжтой болж байгаа юм.

2.2.1 Статик материал нэмэх

ТАУС!-ын толгойн цэсээс орох зам: **Content > Static content manager**



Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Home Site Menu Content Components Modules Mambots Installers Messages System Help

Joomla! / com_typedcontent

Static Content Manager

Filter: [] Order: [Ordering desc] [_SEL_AUTHOR]

#	<input type="checkbox"/>	Title	Published	Order	Access	ID	Links	Author	Date
1	<input type="checkbox"/>	Joomla! License Guidelines		11	Public	5	1	Administrator	19/08/04

<< Start < Previous 1 Next > End >>

Display # [30] Results 1 - 1 of 1

Published, but is Pending | Published and is Current | Published, but has Expired | Not Published

Click on icon to toggle state.



Static content manager дэлгэцнээс **New** товчыг дараад материал оруулах дэлгэцийг гарган мэдээллээ оруулна.

Home Site Menu Content Components Modules Mambots Installers Messages System Help

Joomla! / com_typedcontent / new

Static Content Item: New

Тохиргооны хэсэг

Item Details

1 Title: []

2 Title Alias: []

3 Text: (required)

Түргэн засварлагч

Агуулгаа энд оруулна

Publishing Images Parameters Meta Info Link to Menu

Publishing Info

State: Published

Published:

Access Level: Public

Author Alias: []

Change Creator: Administrator

Override Created Date: []

Start Publishing: 2005-12-14

Finish Publishing: Never

State Published

Hits

Version 0

Created New document

Last Modified Not modified

Expires Never

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

1. Гарчиг (title) Хуудасны гарчигийг оруулна (хуудасны дээр гарч ирэх гарчиг нь энэ болно)
2. Гарчигийн товчлол хувилбар (title alias) Дээрх гарчигтай адил, эсвэл арай богиносгосон байна (заавал оруулах шаардлагагүй)
3. Текст (text (required)) Хуудасныхаа агуулагыг нэмнэ. Текст, зураг, хүснэгт, холбоос, юу ч байж болно



Энэ вед та фонтоо өөрчилөх хэрэггүй. Эдгээрийг дээр бидний ярьсан Вебийн загвар дотор заагдсан тусгай кодоор зохицуулах болно.

Publishing		Images	Parameters	Meta Info	Link to Menu
Publishing Info					
State:	Published				
Published:	<input checked="" type="checkbox"/>				
Access Level:	Public Registered Special				
Author Alias:	<input type="text"/>				
Change Creator:	Administrator				
Override Created Date:	<input type="text"/> ...				
Start Publishing:	2005-12-14 ...				
Finish Publishing:	Never ...				
State	Published				
Hits					
Version	0				
Created	New document				
Last Modified	Not modified				
Expires	Never				

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Тохиргооны секц 5 бүлгээс бүрдэнэ:

- Веб дээр гаргах (**Publishing**)
- Зураг (**Images**)
- Параметрууд (**Parameters**)
- Мета мэдээлэл (**Meta Info**)
- Цэс рүү хандсан холбоос (**Link to Menu**)

“Веб дээр гаргах” бүлэг дэхь тохиргоо нь танд мэдээллийг оруулсан огноог өөрчлөх, хандалтын эрхийг тогтоох, веб дээр гаргаж харуулах хугацааг зааж өгөх боломж олгоно

“Параметр” бүлгээс та хуудсын нэрийг гаргах эсэх, мэдээлэл, дүрс веб дээр гаргаж харуулах бусад ерөнхий тохируулгуудыг зөвхөн энэ бичлэгийн хувьд өөрөөр оруулж өгөх боломжтой. Параметрын талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Нүүр хуудасны компонент” хэсгээс үзнэ үү.



Save товчыг дарж оруулсан мэдээллээ хадгалах буюу



Apply товчыг

дарж мэдээллээ хадгалахын хажуугаар, тохируулах дэлгэцийг нээлттэй хэвээр үлдээх боломжтой.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**Save, Apply хоёрын ялгаа нь юу вэ?**

Save Товчыг дарах нь таны оруулсан мэдээллийг хадгалаад цонхыг хаана.

Харин **Apply** товчыг дарах нь таны мэдээллийг хамгийн сүүлийн байдлаар

хадгалаад цонхыг хаалгуй хэвээр үлдээх юм. Ингэснээр:

- Явцын дунд хийсэн зүйлсээ хадгалаад мөн цааш үргэлжлүүлэх боломжтой болно
- Хийсэн зүйлсээ хадгалаад вебсайтруугаа орж өөрийн оруулсан өөрчлөлтөө хяначихаад хэрэгтэй бол цааш нь өөрчлөх боломжтой болно.

2.3 Оруулсан статик материал руугаа хандсан холбоос үндсэн цэст үүсгэх


Одоо таны веб сайт мэдээлэлтэй болсон хойно танд түүн рүүгээ хандсан холбоос хэрэгтэй. Түүнгүйгээр хэн ч таны шинэ хуудсыг үзэж чадахгүй шүү дээ.


**Оруулсан мэдээлэл болон түүнд хандсан холбоосын талаар сайтар ойлговол зохих хоёр зүйл:**

1. Цэсийн холбоос болоод түүний хандсан мэдээлэл 2 бол хоёр тусдаа зүйл юм. Өөрөөр хэлбэл, ТАУС! вебсайтын мэдээллийг (агуулгыг) доторх цэсүүд болон модулиудаас тусад нь ялгаж хадгалдаг. Цэсийн холбоос болон модулиудын ганц үүрэг нь вебийг үзэж байгаа хүнд веб дээр таны оруулсан мэдээллүүдийг хүргэх явдал болно.
2. Та хандах мэдээллийг нь оруулаагүй байхдаа цэсийн холбоос үүсгэж чадахгүй. Эхлээд мэдээллээ оруулаад, дараа нь холбоосоо үүсгэх ёстой.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах


☞

ТАУС!-ын толгойн цэсээс орох зам: **Menu > Main Menu**


Цэсийн удирдлагын **(Menu Manager)** дэлгэцний баруун дээр байгаа  **New** товчыг дараад шинэ цэсийн элемент үүсгэх боломжтой. ТАУС!-д цэсийн холбоосыг “цэсийн элемент” гэж нэрлэж байгааг тэмдэглэнэ үү.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Шинэ цэсийн элемент (**New Menu Item**) цонхноос, **LINK - Static Content**-ыг сонгоорой:



“Холбоос - Статик мэдээлэл” (Add menu item :: Link - Static content) тохиргооны ЦОНХ - Мэдээлээ цэсийн элементүүдтэй (холбоос) холбох газар.



Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Нэр (<i>name</i>):	Цэсэн дээр гарах бичлэгийн (ε.х холбоосын) нэр.
Холбоосын хандах мэдээлэл (<i>static content</i>)	Цэсийн элементийн хандах мэдээллийг оруул
URL	Єрчлелтєє хадгалсны дараа гарч ирэх хуудасны хаяг
Хуудасны гарч ирэх цонх (<i>On Click, open</i>)	<ol style="list-style-type: none">1. Parent window with browser navigation гэдэг нь холбоос дээр дарахад хандсан мэдээлэлтэй хуудас нь тухайн цонхон дээрээ, хажуу талынхаа цэстэй хамт гарч ирнэ гэсэн үг.2. New window with browser navigation-ыг сонговол хэрэглэгч холбоос дээр дарахад хандсан мэдээлэлтэй хуудас нь шинэ цонхон дээр, хажуу талынхаа цэстэй хамт гарч ирнэ.3. New window without browser navigation-ыг сонговол хэрэглэгч холбоос дээр дарахад хандсан мэдээлэлтэй хуудас нь шинэ цонхон дээр, хажуу талын цэсгвйгээр гарч ирнэ.
Дээд тvвшний бичлэг (<i>Parent item</i>)	Холбоос нь цэсэн дээр vндсэн холбоос маягаар буюу аль нэг vндсэн холбоосын дэд-холбоос маягаар орж болно. “Тор” гэдэгийг сонговол vндсэн цэс дээр шинэ холбоос (vндсэн) болж цэсийн жагсаалтын доор нэмэгдэх бєгєєд харин “Тор” гэсний баруун талын сумыг дараад гарч ирсэн жагсаалтнаас аль нэг ємнє нь байсан vндсэн холбоосыг сонговол тvvний дор дэд-холбоос болон гарч ирэх юм.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Дэс дараа
(ordering)

Цэсийн холбоосуудын дэс дарааг өөрчлөх. Энэ нь зөвхөн хадгалсныхаа дараа идэвхтэй болно

Хандалтын түвшин
(Access level)

Энэ холбоосыг үзэх эрхтэй хэрэглэгчийн түвшинг зааж өгнө. Public, Registered, Special гэсэн 3 түвшний аль нэгийг сонго. Энэ талаар дэлгэрэнгүйг энэ зааврын 7-р хэсгээс үз

Веб дээр тавих
(Published)

Цэсийн элементүүд нь шууд веб дээр тавигдана. Үгүй-г сонгож веб дээр шууд гаргахыг нь болиулж болно.



Save дарж хадгалаад гарах буюу




Apply дарж хадгалаад цааш нь

үргэлжлүүлээрэй.

Жич: АНХНЫ цэсийн элементийн хандсан МЭДЭЭЛЭЛ нь үргэлж *нүүр хуудсан* дээр гарна.


Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**2.4 Цэсийн дэд-холбоос үүсгэх**

Дэд-холбоос үүсгэх арга зам энгийн үндсэн холбоосынхтой яг адилхан. Үндсэн буюу дээд түвшний холбоосууд нь дэд-холбоосуудыг өөртөө агуулж байдаг. Энэ нь веб сайт дээр ийм маягтай харагдана:



ТАУС!-ын толгойн цэсээс орох зам: **Menu > Main Menu**

Гарч ирсэн бидний сайн мэдэх **Menu Manager [main menu]** цонхны дээд секцт

байгаа  **New** товчыг дарж шинэ цэсийн элемент үүсгэнэ

Дараа нь, өмнөхтэйгээ яг адилаар гарч ирсэн **Add Menu Item** (Шинэ цэсийн элемент нэмэх) цонхны **“Link - Static Content”** (“Холбоос - Статик мэдээлэл” гэж дээр орчуулж байсныг та санаж байгаа байх) гэснийг сонгоно:

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



:: Төлөвлөлт

Та шинэ дэд-цэсийн холбоосынхоо хандах мэдээллийг холбоосоо үүсгэхээсээ өмнө оруулсан байх шаардлагатай. Үндсэн цэсийн холбоосны хувьд ч ийм шаардлагатай байдгийг бид өмнө үзсэн билээ.

Тиймээс веб сайтаа хийж эхлэхээсээ өмнө зориуд цаг гаргаад веб хуудасныхаа агуулгыг төлөвлөж яагаад болохгүй гэж? Тэгснээр та агуулгаа ямар байдлаар оруулах талаараа тодорхой төсөөлөлтэй болж, улмаар цаг хугацаа, хвчин чармайлтаа илүү оновчтойгоор зарцуулах боломжтой болно шүү дээ. Ядаж үндсэн гол гэсэн хуудаснуудаа төлөвлөчихвөл их л хэрэгтэй байх болов уу.

“Link - Static Content” цонх:

Үндсэн цэсээс холбоос үүсгэх процесс өмнөхтэйгээ адилхан. Ганц ялгаа нь одоо бид ТАУС!-д энэхүү үүсгэж буй холбоос маань үндсэн биш, дэд-холбоос шүү гэж хэлж өгч байгаа юм. Ингэхийн тулд та “Parent Item” секцт “Top” гэдгийн оронд дэд-холбоосоо агуулахыг хүссэн үндсэн холбоосыг зааж өгөхөд л болно:

Home Site Menu Content Components Modules Manibots Installers Messages System Help

0 1 Logout admin

Joomla / com_menus / edit

Back Save Apply Cancel Help

Add Menu Item :: Link - Static Content

Details

Name:

Static Content: Joomla! License Guidelines()

Url:

On Click, open: Parent Window With Browser Navigation
New Window With Browser Navigation
New Window Without Browser Navigation

Parent Item: Top

Ordering: д баглана.

Access Level: Мэдээ

Published: Холбоосуд
Холбоо барих
Хайлт
News Feeds
FAQs
Wrapper

Parameters

Menu Image: - Do not use an image -

UnitWeb -г худалдан борлуулахыг хориглоно.
UnitWeb 1.0.4 Stable [UnitWeb] 1-Dec-2005 10:00 UTC
Check for latest Version

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

<i>Нэр (name):</i>	Цэсэн дээр гарах дэд-холбоосынхоо нэрийг оруулна.
<i>Холбоосын хандах мэдээлэл (static content)</i>	Энэ холбоос дээр дарахад гарч ирэх мэдээллийг зааж өгнө
<i>URL</i>	Єерчлелтєє хадгалсны дараа гарч ирэх хуудасны хаяг
<i>Дээд тvвшний бичлэг (Parent item)</i>	Жагсаалтнаас аль дэд-холбоосоо доор нь оруулахыг хvссэн холбоосныхоо нэрийг сонго.
<i>Дэс дараа (ordering)</i>	Цэсийн холбоосуудын дэс дарааг єерчлєх. Энэ нь зєвхєн хадгалсныхаа дараа идэвхтэй болно
<i>Веб дээр тавих (Published)</i>	Цэсийн элементvуд нь шууд веб дээр тавигдана. Vгvй-г сонгож веб дээр шууд гаргахыг нь болиулж болно.



Save дарж хийсэн зvйлсээ хадгалахаа мартуузай.

Хоёрдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Шинээр оруулсан мэдээлээ веб дээр тавих, үл тавих тухай - **Publish/Unpublish**

Хэрвээ та холбоосоо оруулсныхаа дараа “веб дээр тавих” сонголтыг сонгосон бол таны вебсайт дээр шинэ холбоос, түүний хандсан мэдээлэл тэр дорoo нэмэгдэх болно. Анхнаасаа сайтын тохируулга таныг мэдээлэл оруулах агшинд түүнийг нь сайт дээр нэмж тавихаар зохицуулагдсан байгаа ч цэсийн холбоосгүй статик мэдээлэлийг тэр нь веб дээр тавигдсан байсан ч хvмvvc олж vзэж чадахгvйг бид өмнө vзсэн.


Хэрвээ та цэсийн холбоосыг vvcгэхдээ vvнийгээ веб дээр тавигдахыг хойшлуулахыг хvсвэл тохируулгын хэсгийн “Published” гэсэн тохиргоон дээрээс VГVЙ гэдэгийг нь сонгоорой. Тэгвэл холбоос нь веб дээр тавигдахгvй учраас цаад мэдээлэл нь таныг ТИЙМ гэж сонготол хэрэглэгчид vзэх боломжгvй хэвээрээ vлдэнэ.

Хэрвээ таны оруулсан мэдээлэл хэрэглэгчдийн хүртээл болохоосоо өмнө өөр хүнээр хянагдах шаардлагатай бол холбоосоо веб дээр тавьчихаад, дараа нь сайтнаасаа холбоос руугаа ороод URL-ийг нь хуулж аваад, буцаагаад холбоосоо веб дээрээсээ авчихаж болно (unpublish)

Дараа нь хуулж авсан URL-аа браузерийн хаягны талбар дээр бичээд, мэдээлээ шууд vзэж болно.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**3.0 Секц (sections), Категори (categories), Бичлэгүүдийн (items) талаар**


Доорх диаграмд секц, категори, бичлэгүүдийн харилцан хамаарлыг дүрсэлсэн байна. Хэрэглэгчдийг энэ төрлийн мэдээлэлийг үзэх боломжтой болгохын тулд та тэдэн рүү хандсан цэсийн холбоос үүсгэх хэрэгтэй. Энэ нь статик мэдээлэл рүү хандсан цэсийн холбоос үүсгэхтэй яг адилхан учир санаа зовох зүйлгүй. Та бүх бие даасан секц, категори, бичлэгүүдэд тус тусад нь холбоос үүсгэх боломжтой.



Таны веб сайт шинэ мэдээний секцтэй, тэндээ хамгийн шинэ мэдээний категори болон мэдээний бичлэгүүдтэй байх болно гэж үзье. Ингээд уг хэсгийг хэрхэн үүсгэх, засах талаар жишээ аван ярилцъя. Өөр ямар ч секц, категори үүсгэсэн бидний жишээн дээрхтэй адилхан байх болно.

Section Manager танд веб сайт дээрх бие даасан хэсгүүдийг харж, засах боломж олгоно. Зарим хэсгүүд, тухайлбал мэдээний секц үндсэн загварт цаанаасаа тохируулагдаад орчихсон байгаа. Үүн дээр таны өөрийн хэсгүүд нэмэгдэх юм.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



Дээр та мэдээний секц рүү хандсан энгийн болон шинэ мэдээний бичлэгүүд рүү шууд хандсан *Шинэ мэдээний* модулийн гэсэн хоёр янзын холбоос байгааг харж байна. Энэхүү веб дээр шинэ мэдээний 5 бичлэг модуль дээр гарсан байна. Энэ модулийн талаар бид дараа дэлгэрэнгүй үзэх болно. Одоохондоо мэдээний хэсгийнхээ талаар ярилцъя.



:: Бvв март


Веб дээрээ зөвхөн ямар нэг зүйлийн секц үүсгэснээр тэр нь автоматаар хvн болгоны хүртээл болохгvй. Та vнний тулд тэр секц рvүгээ хандсан холбоосыг мөн үүсгэх хэрэгтэй шvв. (яг статик мэдээлэлтэй адилхан байгаа биз)

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах


3.1 Секц үүсгэх, засварлах

Section Manager

ТАУС!-ын толгойн цэсээс орох зам: **Content > Section Manager**




Удирдлагын цонхон дээр секц болгоны талаар мэдээллийг харуулсан байна. Үүнд тухайн секцт байгаа категориудын тоо (доор 3 байна), хандалтын зэрэг (3-лаа public хандалтын зэрэгтэй юм), идэвхтэй бичлэгүүдийн тоо (# Active гэсэн баганын доороос үз) багтаж байна.



Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Хүссэн секцээ өөрчлөхийн тулд нэрэн дээр нь дарж **Section: Edit** цонхыг гаргаж ирнэ:



Section Details буюу секцийн детальчилсан тохиргооны хэсэг дэхь зарим өмнө гарч байгаагүй тохируулгуудыг тайлбарлая:

Title гэсэн талбар дээр бичсэн нэр ТАУС-д таны секцийг уг нэрээр оруулж хадгалахаас гадна цаашид тухайн секц рvv хандсан холбоосны нэр болон гарч ирнэ (энэ нь уг холбоосны нэрийг өөрөөр өгөх боломжгүй гэсэн үг биш л дээ)


Section Name гэдэг нь таны секц веб дээр гарч ирэхэд дээр нь гарах нэр болох юм.

Image гэдэг дээр зураг зааж өгвөл тэр нь веб дээр секцний тань зураг болон гарч ирнэ. Харин аль талд нь гарч ирэхийг **Image Position** дээрээс тохируулаарай.

Description хэсгийг ашиглан секцийнхээ танилцуулгын текстийг өөрчилөх боломжтой.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Одоо бүгдээрээ дээрх секц веб дээр ямар байдлаар харагдаж байгаа харъя:




1. Бидний **Section Name** хэсэгт оруулсан нэр маань дээд талынх нь гарчиг болон орсон байна.
2. **Image** хэсэгт заасан зураг маань **Image Position**-д хэлж өгсний дагуу баруун гар талд нь гарчээ
3. **Description** хэсэгт оруулсан текст мөн л секцийн танилцуулга маягаар эх хэсэгт нь гарч ирсэн байна

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах


3.2 Категори үүсгэх, засварлах

Категорийн удирдлагын цонхонд дараах хаягаар орно:

Content > Category Manager



Засч өөрчлөхийг хвссэн категорийнхоо нэрэн дээр нь дарж Category: Edit цонхыг гаргаж ирнэ:



Category Details буюу категорийн детальчилсан тохиргооны хэсэг дэхь зарим өмнө гарч байгаагвй тохируулгуудыг тайлбарлая:

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Category Title гэсэн талбар дээр бичсэн нэр ТАУС-д таны категорийг уг нэрээр оруулж хадгалахаас гадна цаашид тухайн категори руу хандсан холбоосны нэр болон гарч ирнэ.

Category Name гэдэг нь таны категори веб дээр гарч ирэхэд дээр нь гарах нэр болох юм.

Image гэдэг дээр зураг зааж өгвөл тэр нь веб дээр категорийн тань зураг болон гарч ирнэ. Харин аль талд нь гарч ирэхийг **Image Position** дээрээс тохируулаарай.

Description хэсгийг ашиглан категорийнхаа танилцуулгын текстийг өөрчилөх боломжтой.

~~ секц, категори, юу ч өөрчилж, нэмсэн хоорондоо хичнээн адилхан, хялбархан байгааг та харж байгаа биз!


Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

☞

Харин одоо дээрх категори веб дээр ямар байдлаар харагдаж байгаа харъя:




Шинэ мэдээний холбоос дээр дарахад доорх цонх гарч ирнэ. Дээр бичсэнчлэн 5 бичлэг энэхүү категори дотор байна. Категорийн нэр, зураг, тайлбар сэлт бүгд таны ТАУС дээр оруулж өгсний дагуу гарч ирсэн байгааг харж болно:




Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах**3.3 Категори дотор бичлэг үүсгэх, түүнийг засварлах**


Content Item Manager цонхноос та шинэ мэдээний бичлэг үүсгээд, түүнийгээ секцүүд доторх категориудаас тохироход нь хуваарилах боломжтой. Жишээ болгон бүгдээрээ шинэ мэдээний категорид мэдээний бичлэг нэмж үзье:

ТАУС-ын толгойн цэсээс орох зам: **Content > Content by Section > News > News Items:**



Гарч ирсэн **Content Items Manager** цонхноос  **New** товчин дээр дарж Шинэ мэдээний категорид мэдээ оруулах боломжтой:

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах



Гарч ирсэн **Content Item: New** цонхны **Item details** талбар дээр мэдээнийнхээ агуулгыг бичиж оруулна. Мөн баруун талын тохиргооны хэсэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэ хоёр хэсгийг тус тусад нь авч үзье.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Мэдээллийнхээ агуулгыг оруулах **Item Details** талбар:



Content Item: Edit [Section: Мэдээ]

Item Details

Title:	Жишээ -1	Section:	News
Title Alias:	Жишээ -1	Category:	Шинэ мэдээ

Intro Text: (required)

B I U ABC | [List icons] | -- Styles -- | -- Format --

[Rich text editor icons: bulleted list, numbered list, link, unlink, image, video, audio, table, etc.]

МУ-ын Засгийн газар, Мэдээлэл, Харилцаа холбоо, Технологийн газар, Компьютер нийлүүлэгчдийн холбоо (MASCO)-оос хамтран хэрэгжүүлж буй "Бүх нийтийг компьютержүүлэх" хөтөлбөрийн I-р үе шатны хаалтын ажиллагаа 2005 оны 12 дугаар сарын 14-ны 14 цагаас Мэдээлэл Технологийн Үндэсний Паркад зохион байгуулагдах гэж байна.

Title гэсэн хэсэгт нь бичлэгнийхээ нэрийг (гарчиг) оруулна. Энэ гарчиг нь веб дээр таны бичлэгийн дээд талд гарч ирнэ.

Section дээрээс уг мэдээллийнхээ агуулагдах секцийг зааж өгнө. Уг бичлэгийг дотор нь үүсгэж буй категорийг агуулж буй секцийн нэр автоматаар орж ирсэн байна.

Category хэсэгт бичлэгийнхээ дотор нь орох категорийг сонго

Intro Text хэсэгт бичлэгийнхээ агуулгыг оруулна. Түргэн засварлагчийг (**WYSIWYG Editor**) ашиглан зураг, текст, вебийн холбоос гэх мэтийг оруулах боломжтой.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Бичлэгийнхээ харагдах байдал сэлтийг зааж өгөх тохиргооны хэсэг:

Publishing Info	
Show on Frontpage:	<input type="checkbox"/>
Published:	<input checked="" type="checkbox"/>
Access Level:	Public Registered Special
Author Alias:	
Change Creator:	Administrator
Ordering:	Шинэ бичлэг хамгийн эхэнд байрлана.
Override Created Date:	
Start Publishing:	2005-12-15
Finish Publishing:	Never
State: Published	
Hits :	
Revised :	0 times
Created	New document
Last Modified	Not modified

Ерөнхийдөө хамгийн их хэрэглэгдэх нь дээр харагдаж буй веб дээр тавих тохиргооны бүлэг (**Publishing info**) байх болов уу. Энд та бичлэгээ веб дээр хэрхэн харагдахыг зааж өгөх боломжтой. Веб дээр тавилгвй үлдээхийн тулд **Published** сонголтын ард шувуу нисгэлгвй орхиорой.

Бичлэгээ вебийнхээ нүүр хуудсан дээр гаргая гэвэл **Show on Frontpage**-ыг сонгоно.

Хэрэглэгчдийн хандалтын зэрэгийн (**Access Level**), тохиргоог бид мэднэ. **Author Alias** гэсэн талбар дээр бичлэгийг үйлдсэн хүний нэрийг оруулж өгөх боломжтой. **Change Creator** гэдэг дээр бичлэгийн веб дээр тавьж байгаа хүний нэрийг сонгож өгнө.

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Override Created Date гэдэг нь бичлэгийг оруулсан огноог үл хайхран, өөрийн хвссэн огноогоо албаар дарж оруулахад ашиглагддаг. Энэ бичлэгийг хэзээ оруулснаас үл хамааран энэ талбарт оруулж өгсөн огноод оруулагдсан мэтээр веб дээр харагдах болно.

Start Publishing - Бичлэгийн веб дээр тавьж эхлэх огноо

Finish Publishing - Бичлэгийг вебээс авах (хэрэглэгчидэд харагдахыг нь болиулах) огноо. Энд огноогоо оруулахдаа баруун талын товчин дээр дараад гарч ирсэн календарийг ашиглаарай. Харин хэзээ ч вебээс авахгүй байхыг хүсвэл “Never” гэж оруулж өгөх хэрэгтэй

Гуравдугаар хэсэг: Сайтын агуулга, холбоосуудыг оруулах

Шинэ мэдээний категори болон мэдээний бичлэгүүд веб сайт дээр харагдах байдал:

The screenshot shows the Uni!Web CMS interface. On the left is a sidebar with navigation menus. The main content area displays a news list with columns for date, author, and number of views. Several red and purple boxes highlight specific features:

- Категорийн нэр** (Category name) - points to the 'Мэдээ' (News) menu item in the sidebar.
- Шинэ мэдээний модуль хамгийн сүүлд уншигдсан, хамгийн олон уншигдсан мэдээнүүдийг гаргахаар тохируулагдсан байна** (The new news module displays the most recently read and most read news items, sorted accordingly) - points to the 'Шинэ мэдээ' (New news) section.
- Бичлэгүүд рvv хандсан холбоос** (Links to the posts) - points to the 'Холбоо барих' (Contact) menu item in the sidebar.

The news list table is as follows:

Огноо	Гарчиг	Зохиогч	Уншсан
2004/07/07	Жишээ -1	Administrator	8
2004/07/07	Жишээ-2	Administrator	3
2004/07/07	Жишээ - 4	Administrator	8
2004/06/12	МАУС! -д тавтай морил	Web Master	6
2004/04/12	Жишээ - 3	Administrator	1

Жишээ-1 дээр дарахад бичлэг доорх байдалтай гарч ирнэ:

The screenshot shows a news article page titled "Жишээ -1". The content is as follows:

Жишээ -1

Бичсэн: Administrator
2004/07/07

МУ-ын Засгийн газар, Мэдээлэл, Харилцаа холбоо, Технологийн газар, Компьютер нийлүүлэгчдийн холбоо (MАСO)-оос хамтран хэрэгжүүлж буй "Бүх нийтийг компьютержүүлэх" хөтөлбөрийн I-р үе шатны хаалтын ажиллагаа 2005 оны 12 дугаар сарын 14-ны 14 цагаас Мэдээлэл Технологийн Үндэсний Паркад зохион байгуулагдах гэж байна.

шинэч. (2005/12/13)

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль**4.0 Шинэ мэдээний модулийн талаар**

Шинэ мэдээний модуль гэдэг маань тодорхой секц дэхь заасан категори дотор байгаа бичлэгүүд рүү хандсан идэвхтэй холбоосуудыг гаргаж харуулах үүрэгтэй нэмэлт программ юм. Хэдэн бичлэгийн холбоосыг нэг дор харуулах, веб хуудасны аль секцт байрлах зэргийг параметрийн тохиргоон дээр зааж өгнө (цаанаасаа мэдээний категориос авдаг байхаар таны шинэ веб дээр тааруулагдсан байгаа)

Уг модулийн ажиллагааг ойлгохын тулд та вебийн бие даасан хэсгүүдийн хоорондын харилцан хамаарлыг ойлгох хэрэгтэй. Үнэндээ бол энэ модуль нь аль ч секцийн аль ч категориос холбоос аван дэлгэцэн дээр харуулах боломжтой боловч одоохондоо ТАУС!-ыг суулгахтай хамт суучихсан байгааг нь бодолцоод шинэ мэдээний категори дээр л ажиллаж үзье.

Модулиудын талаар та манай салангид *“Модуль хэрхэн ашиглах тухай”* заавраас илүү дэлгэрэнгүйгээр үзнэ үү.

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль

4.1 Шинэ мэдээний модулийг тохируулах: деталь, параметр, хуудасны хуваарилалт

Толгойн цэсээс орох зам: **Modules > Site modules**

Module Manager цонхноос Шинэ мэдээний модулийг сонгоно

Энэ модуль таны ТАУС дээр “Latest News” гэсэн нэрээр байгаа болов уу. Хэрвээ та шинэ мэдээний категоринхоо нэрийг өөрчилсөн бол тэр нэрээр гарч ирэх болно.


Site Module: Edit цонх

The screenshot shows the Joomla! administration interface for editing a site module. The top navigation bar includes links for Home, Site, Menu, Content, Components, Modules, Mambots, Installers, Messages, System, and Help. The user is logged in as 'admin'. The main content area is titled 'Site Module: Edit [Шинэ мэдээ]'. It is divided into two panels: 'Details' and 'Pages / Items'. The 'Details' panel contains the following fields: Title (Шинэ мэдээ), Show title (radio buttons for 'None' and 'Yes'), Position (user1), Module Order (1: Шинэ мэдээ), Access Level (Public, Registered, Special), Published (radio buttons for 'None' and 'Yes'), ID (6), and Description. The 'Parameters' section includes Module Class Suffix, Enable Cache (radio buttons for 'No' and 'Yes'), and Module Mode (Content Items only). The 'Pages / Items' panel shows a list of menu items with 'mainmenu | Мэдээ' selected.

“**Details Setup**” гэсэн хэсэгт та модулийнхаа хуудсан дээр хаана байрлахыг (зүүн буюу баруун талд гэх мэт), дэс дараа (харьцангуй), гарчигийг нь харуулах эсэх, шууд веб дээр тавих эсэх, хэрэглэгчийн хандах эрхийн түвшин зэргийг зааж өгнө. Мөн эндээс **Pages/Items** тохиргоогоор модулиа аль аль хуудсан дээр гаргахыг тохируулах юм. Эдгээрийн мөн тус тусад нь авч үзье.

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль

Details Setup хэсэг:

 **Site Module: Edit [Шинэ мэдээ]**

Details

1 Title:

2 Show title: Үгүй Тийм

3 Position:

4 Module Order:

Access Level:

Published: Үгүй Тийм

ID: 6

Description: This module shows a list of the most recently published items that are still current (some may have expired even though they are the most recent). Items that are displayed on the Front Page Component are not included in the list.

Parameters

Module Class Suffix:

Enable Cache: No Yes

Module Mode: 5

Frontpage Items: show hide

Count: 6

Category ID:

Section ID: 7

1. Title гэсэн хэсэгт модулийнхаа веб дээр харагдах нэрийг бичиж оруулна.

Цаанаасаа модулийн өсрийнх нь нэр болох “шинэ мэдээ” гэсэн үг энд орчихсон байгаа. Хүсвэл өсрчилж болно.

2. Show title дээр “Үгүй” гэдгийг сонговол дээрх гарчиг веб дээр харагдахгүй

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль

3. Show position: Эндээс та модулиа веб хуудасны хаана гаргаж ирэхийг сонгох юм. Англи хэл дээр олон янзын байршлуудаас сонгож болно. Тухайлбал “right” гэдэг нь сайтын баруун талд, “left” гэдэг нь зүүн талд, “user1” гэдэг нь сайтын дунд хэсэгт гаргах жишээтэй. Хаана хаана гарч ирэхийг та өөрөө тавьж үзнэ үү.

4. Module Order: Өөр модультай хамт тавигдаж байгаа бол алийг нь дээр нь гаргахыг энд шийднэ. Манай жишээн дээр ганц модуль байгаа.

5. Module Mode: Категори доторх бичлэгийг ашиглахуу, эсвэл статик мэдээлэл ашиглахуу, эсвэл хоёуланг нь уу гэдэгээ эндээс зааж өгнө.


6. Count: Модуль дотор холбоосыг нь харуулах бичлэгийн тоо

7. Category ID, Section ID: Энд та модуль нь аль секцийн аль категорид байгаа бичлэгүүдийн холбоосыг гаргахыг хэлж өгнө. Section/Category Manager хэсгээс тодорхой секц, категориудын ID-г үзнэ үү.

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль

Pages/Items хэсэг:

Модулийг нэг буюу хэд хэдэн веб хуудсанд оруулж өгөх Pages/Items тохиргооны хэсэгт зөвхөн хандсан холбоос нь веб дээр тавигдсан хуудсууд гарч ирнэ. Учир нь ТАУС! маань жинхэнэ мэдээлэлтэй хуудсыг биш, хуудсууд руу хандсан холбоосуудыг л “хардаг” юм. Тиймээс та тодорхой хуудсан дээр модуль тавихыг хүсвэл уг хуудасныхаа холбоосыг веб дээр тавигдсан эсэхийг шалгаарай. Үгүй байвал та тэр хуудсаа дээрх тохиргооны хэсэг дээр харахгүй байх нь байна шүү дээ



Энэхүү жагсаалтаас та модулиа дээр нь гаргахыг хүссэн бүх хуудсаа сонгож өгөх хэрэгтэй. Олон хуудас сонгохын тулд гарынхаа CTRL товчыг ашиглаарай. Уг товчыг дараад, хуруугаа авалгүйгээр хуудсуудынхаа нэр дээр дарснаар бүгд идэвхижих болно.

Дууссаныхаа дараа



Save-ийг дарж хадгалах буюу




Apply-г дарж

хадгалж\хяна.

Дөрөвдүгээр хэсэг: Шинэ мэдээний модуль

Манай Шинэ мэдээний модуль вебсайт дээр харагдаж буй байдал:



:: Вебийн секц, категориудын ID-г хаанаас олох вэ?

Шинэ мэдээний модулийн цаанаас ирсэн тохиргоо нь таны ТАУС!-тай хамт суусан шинэ мэдээний категориос (мэдээний секц дэх) мэдээлээ авахаар тааруулагдсан байгаа. Харин сүүлд та нэгээс олон секц\категоритой болсныхоо дараа модулиа алинаас нь бичлэгүүдээ авахыг нь зааж өгөх боломжтой. Та тодорхой секц, категориын дугаарыг секц, эсвэл категориын удирдлагын цонхноос нь олж болно. (Section manager эсвэл Category manager - хандах зам: **Content > Section/Category Manager**)

Category Manager [Content: All]

#	Category Name	Published	Order	Access	Section	Category ID	# Active	# Trash
1	Шинэ мэдээ (Latest)		1	Public	News	1	5	0
2	Newsflash (Newsflash)		1	Public	Newsflashes	3	2	1
3	Example FAQs (Examples)		1	Public	FAQs	7	2	0

Display # 30 Results 1 - 3 of 3

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Та браузер дээр сайтныхаа хаягийг бичээд ороход, эсвэл eep веб хуудаснаас танайх руу хандсан холбоосыг дагаж ороход хамгийн тvrvvнд таны нvvp хуудас гарч ирэх болно.

5.0 Нvvp хуудасны компонентийн тухай

Таны vндсэн цэсийн эхний элемент (холбоос) нь нvvp хуудасны компонент байх юм бол параметрийн тохиргоон дээр нь “нvvp хуудасны” гэж зааж eгсэн бvх мэдээний бичлэг вебийн нvvpрэн хэсэгт гарч ирэх болно. E.х Энэ тохиргоо мэдээллийг нvvp хуудсан дээр гаргах чанартай учраас параметрын тохиргоон дээрээ ийнхvв заагдсан ямар ч бичлэг нvvp хуудсан дээр гарах юм.

Цэсийн удирдлага дахь бvх цэс eepийн гэсэн цэсийн модультай байх бeгeед тэр нь веб дээр тавигдсан байж цэс нь веб дээр гарч ирэх болно (энэ талаар илvв ихийг Модулийн гарын авлагаас vз). ГЭВЧ, vндсэн цэсийн модуль веб дээр тавигдаагvй байсан ч, таны вебийн нvvp хуудсан дээрх vндсэн цэсийн байранд хамгийн анх веб дээр тавигдсан холбоос гарч ирэх болно.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

ТАУС!-ыг суулгахад ирсэн стандарт тохиргоон дээр веб нь Нvvp хуудасны компонентийнг анхны веб дээр тавигдсан цэсийн элементийн (холбоос) хандах зvйл болгож vндсэн цэсэнд оруулсан байгаа. Тиймээс, стандарт вебийн хувьд vндсэн цэсийн удирдлагын цонх доорх байдалтай харагдах юм:

Home Site Menu Content Components Modules Mambots Installers Messages System Help 0 1 Logout admin

Joomla / com_menus Publish Unpublish Move Copy Trash Edit New Help

Menu Manager [mainmenu] Max Levels 10 Filter:

_MAINMENU_DEL
_MAINMENU_HOME

#	<input type="checkbox"/> Menu Item	Published	Reorder	Order	Access	Itemid	Type	CID
1	<input type="checkbox"/> Нvvp хуудас			1	Public	1	Component - FrontPage	10
2	<input type="checkbox"/> МАУС! -н лиценз			2	Public	6	Link - Static Content	5
3	<input type="checkbox"/> Мэдээ			3	Public	2	Table - Content Section	1
4	<input type="checkbox"/> Шинэ мэдээ			1	Public	26	Link - Static Content	5
5	<input type="checkbox"/> Мэдээллийн самбар			4	Public	9	Blog - Content Section	0
6	<input type="checkbox"/> Холбоосууд			5	Public	23	Component - Web Links	4
7	<input type="checkbox"/> Холбоо барих			6	Public	3	Component - Contacts	7
8	<input type="checkbox"/> Хайлт			7	Public	5	Component - Search	16
9	<input type="checkbox"/> News Feeds			8	Public	7	Component - News Feeds	12
10	<input type="checkbox"/> FAQs			9	Public	25	Table - Content Category	7
11	<input type="checkbox"/> Wrapper			10	Public	8	Wrapper	0

<< Start < Previous 1 Next > End >>

Display # 30 Results 1 - 11 of 11

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Вебсайтын дизайн

Нvvp хуудасны компонентээр дамжиж нvvpрэн дээр тавигдсан мэдээлэл болгон дандаа блог хэлбэрээр (веблог гэдэг vгийн товчлол) буюу нэгээс хоёр догол мep нь л уншигчдад ерөнхий ойлголт eгeх vвднээс харагдаад, доороо бvрэн нийтлэл руу хетлэх “цааш нь унших” гэсэн холбоостойгоор гарч ирнэ.



:: Блогуудын талаар товчхон:

Блогын веб дээр тавигддаг дээрх хэлбэр нь байнга шинэчлэгдэж байдаг мэдээллийг, жишээлбэл шинэ мэдээ, мэдээллийг гаргаж харуулахад маш тохиромжтой. Вебийн администраторын хувьд та блогийн хэлбэрийг ашиглдаггvй байлаа ч гэсэн vvнийг мэдэхэд илvvдэхгvй:

МАУС! -д тавтай морил

Бичсэн: Web Master
2004/06/12

Та хэрвээ Агуулгын Удирдлагын Систем(АУС) -н талаар урьд нь сонсч байсан бол энэ нь веб сайт бүтээх, бий болгох хамгийн үр дүнтэй хурдан хэрэгсэл юм гэдгийг ойлгодог гэдэгт эргэлзэхгүй байна.

Sample
Image

Example Caption

МАУС бол портал вебсайт бүтээх бусад програм хангамжуудаас маш олон давуу талтай. Тухайлбал: МАУС нь маш өргөн боломжтой . Мaсст зориулан бүтээгдсэн, ямар ч төрлийн вебсайт боловсруулж болно. Суулгах, удирдахад маш энгийн. МАУС нь хэрэглэгч, оператороос HTML, PHP гэх мэт програмчлалын хэлний мэдлэг шаардахгүй

шинэч. (2005/12/05)

Дэлгэрэнгүй**Newsflash 1**

Бичсэн: Administrator
2004/08/09

МАУС! 1.0 - 'Эрх чөлөөг мэдэрье!'. Өөрийн веб сайтаа бүтээхэд хэзээ ч ийм амархан байгаагүй...

шинэч. (2005/12/05)

Newsflash 2

Бичсэн: Administrator
2004/08/09

Өчигдөр буюу 2005 оны 12 сарын 17 -ны өдөр МХХТГ төрийн байгууллагуудыг МАУС! ашиглан веб сайттай болоход нь зориулан веб серверүүдийг худалдан авлаа

шинэч. (2005/12/05)

Бид дараа нийтлэлийн загварыг, хэдэн баганатайгаар харагдах, танилцуулах бичлэгүүд, гол бичлэгүүд тэргүүтнийг Нvvp хуудасны компонентийн цэсийн элементийн параметр хэсгээс хэрхэн eерчлeхийг vзэх болно.

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

Харин та Нvвр хуудасны компонентод холбогдсон бvх мэдээллийг харуулдаг стандарт нvвр хуудасны загварыг хэрэглэхийг хvсэхгvй байгаа бол


Таны хийвэл зохих зvйл гэвэл ердєє нvвр хуудсандаа зориулсан секц мэдээлэл, статик мэдээлэл ч юмуу оруулаад, vндсэн цэсээс vндээ хандсан холбоос vүсгээд, дараа нь Нvвр хуудасны компонент рvү хандсан холбоосыг веб дээрээс авах буюу бvр устгахад л болох юм. Харин дараа нь шинээр оруулсан нvвр хуудасныхаа мэдээлэл рvүгээ хандсан холбоосыг vндсэн цэсний эхний бичлэг болгох хэрэгтэй. Хялбархан байгаа биз!

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

5.1 Нvвр хуудасны компонентийн тохиргоог хийх

Толгойн цэснээс орох зам: **Content > FrontPage Manager**

Стандарт тохиргоотой вeд Нvвр хуудасны компонентийн цонх иймэрхvв харагдах болов уу: Энд бvх мэдээлэлийн бичлэгvвд параметр дээрээсээ “нvвр хуудас” руу холбогдсон байгааг та харж байна



The screenshot shows the Joomla! administration interface for the Frontpage Manager component. The top navigation bar includes links for Home, Site, Menu, Content, Components, Modules, Mambots, Installers, Messages, System, and Help. The user is logged in as 'admin' and is viewing the 'com_frontpage' section. The main content area displays a table of news items with columns for #, Title, Published, Reorder, Order, Access, Section, Category, and Author. The table contains three rows of data, each with a lock icon and a 'Published' status icon. Below the table, there are navigation controls for pagination and a display count of 30 items.

#	Title	Published	Reorder	Order	Access	Section	Category	Author
1	МАУС! -д тавтай морил			1	Public	Мэдээ	Шинэ мэдээ	Web Master
2	Newsflash 1			2	Public	Newsflashes	Newsflash	Administrator
3	Newsflash 2			3	Public	Newsflashes	Newsflash	Administrator

Нvвр хуудасны компонентийн цонх Мэдээний бичлэгийн удирдлагын цонхтой тeстэй тохиргоонуудтай. Гэвч vүний дээр нvвр хуудасны компонентийн eерийнх нь шинж чанартай холбогдсон тохиргоонуудаас гадна eер удирдлагын самбарт байхгvй “устгах” функц энд бий.



Архив гэсэн товч дээр дарж мэдээллийн бичлэгvвдийн архивлана. Энэ нь устгаж байгаа хэрэг биш - архивлагдсан зvйлсийг буцаан задалж, нvврхуудасан дээр эргvүлэн гаргаж болно.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Нvvp хуудасны мэдээллийн бичлэгийг вебийн нvvpэн дээр буцаан гаргахдаа:

1. **Content > Archive Manager** гэж ороод буцаан гаргахыг хvссэн бичлэгээ



сонгоод зvvn дээд талд байгаа **Unarchive** товчыг дарна

2. Нvvp хуудасны удирдлагын секцт очоод та саяны бичлэгээ задарчихсан байгааг харах болно - **Publish** (веб дээр тавих) товчыг дараад веб дээрээ гаргана.

Remove: Энд дарж мэдээллийн бичлэгийн Нvvp хуудасны компонентээс устгаж болно (ингэснээр вебийнхээ нvvp хуудсан дээр дахин гарч ирэхгvйгээр устгана гэсэн vг). Энэ товчыг дарсны дараа мэдээлэл тэр чигээрээ устгагдахгvй, зөвхөн нvvp хуудасны бичлэг байхаа л больж байгаа гэдгийг анхаарна уу. Тэд нь одоо зөвхөн мэдээний бичлэгvүдийн удирдлагын цонхон дээрээс л харагдах болно.

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

Дэс дарааны багана:

Нvвр хуудасны компонентд, мэдээний бичлэгvвдийн дэс дараа нь vндсэн цэс дэх холбоосны тохиргооноос хамаарна. Тухайлбал, та нvвр хуудсанд холбогдсон 4 салангид мэдээний бичлэгтэй байсан гэе. Тэгээд та цэсийн элемент буюу холбоосон дээр хоёр гол бичлэг, хоёр танилцуулгын бичлэг байхаар зааж өгсөн гэвэл уг 4 бичлэгийн эхний хоёр нь гол, дараагийн хоёр нь танилцуулгын бичлэг болох болно. Энэ дараалал нь мэдээж Нvвр хуудасны компонент гарч байгаа вед л хvчинтэй байх юм.

5.2 Нvвр хуудасны компонент рvв хандсан холбоос vвсгэх

Эхлэхээсээ өмнө ТАУС-д цэсийн элемент гэдэг маань цэсийн *холбоосны* өөр нэг нэр нь гэдгийг дахин сануулъя!

Нvвр хуудасны компонентд хандсан холбоос vвсгэх 2 зам бий:

1. Нvвр хуудасны компонентд хандсан холбоос vвсгэх (vндсэн цэсийг жишээ болгон авъя):

Толгойн цэсээс орох зам: **Menu Manager > Mainmenu**



Гарч ирсэн **“Menu Manager”** цонхноос **New** товчыг дарна:

Шинэ цэсийн элементийн цонхноос **“Component”**-ийг сонгоно

Дараа нь гарч ирсэн цонхны **“Details”** хэсэг дэх **Component** талбараас

FrontPage гэдгийг сонгоно.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Эсвэл:

2. Компонентийн бичлэг рvу хандсан холбоос vvcгэх (vндсэн цэсийг жишээ болгон авъя):

Толгойн цэсээс орох зам: **Menu Manager > Mainmenu**



Гарч ирсэн **“Menu Manager”** цонхноос **New** товчыг дарна


Шинэ цэсийн элементийн цонхноос **“Link - Component Item”**-ийг сонгоно.

Дараа нь гарч ирсэн цонхны **“Details”** хэсэг дэх **Component to Link** талбараас нvvp хуудасны компоненттэй холбогдсон холбоосны **НЭРИЙГ** сонгоно. Ихэнх тохиолдолд энэ холбоос **Home**, эсвэл Монголоор **Нvvp Хуудас** гэдэг нэртэй байна.

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

New Menu Item цонхноос **Component** юмуу, **Link - Component Item**-ийг

СОНГОНО:



Компонентийн бичлэгийн холбоостой холбох нь (Link - Component Item) нөгөө аргаасаа (Component) юугаараа еер вэ?

Бичлэгийн холбоос рvv нь хандсан холбоос нь тухайн холбоосын параметрийн тохиргоог еер дээрээ авдаг. Тиймээс энэ холбоосны хувьд зөвхөн деталийн тохиргоог л еерчлэх боломжтой. Та оригиналь холбоосны бvх тохиргоог (загвар, хандсан мэдээлэл г.м) тэр чигээр нь хуулж авах болно. Нэмэлт деталийн тохиргоо нь холбоос дээр дарсны дараа мэдээлэл ямар цонхон дээр гарч ирэхийг тохируулах боломж олгоно.

Ямар вeд энэ аргыг ашиглах вэ?

Хэрвээ та Нvвр хуудасны компонентийнг нэгээс олон холбоос дээр ашиглахыг хүсэхийн дээр нэг тогтоосон параметраа бvгдэд нь ашиглахдаа дургvйцэхгvй бол vннийг ашиглаарай. Хэрвээ анхны Нvвр хуудасны компонентийн цэсийн элемент (холбоос) -д параметрийн тохиргоо хийж егсегvй бол стандарт тохиргоог ашиглана.

Тавдугаар хэсэг: Нvр хуудасны компонент

5.3 Нvр хуудасны компонентийн цэсийн элементийн (холбоос) тохиргоог хийх

Нvр хуудасны компонент рvв хандсан холбоосын деталь болон параметрийн тохиргоог хэрхэн хийхийг vзэцгээе. Юуны өмнө дээрх 2 аргын аль нэгийг нь ашиглаад цэсийн элемент vүсгэх процессоо эхлvүлнэ.

Add Menu Item: Component цонх:

Цэсийн элементийн деталийг тохируулах:

Name - Нэр:

Цэс дээр гарч ирэх холбоосныхоо нэрийг оруулна

Component - Компонент:

Нvр хуудсаа сонго. Энэ тохиргоог хадгалсны дараа өөрчлөх боломжгvй.

URL:

Өөрчлөлтөө хадгалсны дараа гарч ирэх хуудасны хаяг

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент**Parent Item:**

Холбоос нь дээд (vндсэн) тvвшинд буюу аль нэг vндсэн холбоосны дэд-холбоос маягаар орж болно. Эндээс ямар нэг vндсэн холбоос сонговол тvvний дэд-холбоос маягаар орох юм

Ordering - Дэс дараа:

Цэсийн холбоосуудын дэс дарааг еерчлэх (хадгалсныхаа дараа). Шинэ холбооснууд цаанаасаа холбооснуудын жагсаалтын хамгийн дор гарч ирэхээр тохируулагдсан.

Opening window:

Холбоосын нээгдэх цонх

Нvvp хуудасны компонентийн холбоосонд л зевхен энэ тохируулгыг еерчлэх боломжтой. Эндээс холбоосон дээр дарсны дараа хандсан мэдээлэл нь браузерийн ямар цонхон дээр гарахыг тохируулна

Access Level - Хандалтын зэрэг: Холбоосыг vзэх эрхтэй хэрэглэгчийн зэрэгийг оруул.

Publish - Веб дээр тавих:

Цэсийн элементvуд нь шууд веб дээр тавигдана. Vгvй-г сонгож веб дээр шууд гаргахыг нь болиулж болно.


Тавдугаар хэсэг: Нvvр хуудасны компонент

5.4 Нvvр хуудасны компонентд хандсан холбоосын тохиргоог хийх

Шууд компонент руу хандсан буюу 1 дэх аргаар холбоос vvcгэсэн бол хуудас маань яаж харагдахыг заадаг параметрийн тохиргоог хийх хэрэгтэй.



Apply товчыг дарж хийсэн ажлаа хадгалаад, цэсийн элементийн тохируулгын цонхоо хаалгvй vлдээхэд параметрийн тохиргоогоо гаргаж ирнэ. Параметрийн тохиргооны бvлэг доорх байдалтай байдаг:

 **Edit Menu Item :: Component [FrontPage]**

Details	
Name:	<input type="text" value="Test"/>
Component:	FrontPage
Url:	index.php?option=com_frontpage&Itemid=28
Parent Item:	<input type="text" value="Top"/>
Ordering:	<input type="text" value="12 (Test)"/>
Access Level:	<input type="text" value="Public"/> <input type="text" value="Registered"/> <input type="text" value="Special"/>
Published:	<input checked="" type="radio"/> Үгүй <input type="radio"/> Тийм

Parameters	
Menu Image	<input type="text" value="- Do not use an image -"/>
Page Class Suffix	<input type="text"/>
Page Title	<input type="text"/>
Page Title	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Back Button	<input type="text" value="Hide"/>
# Leading	<input type="text" value="1"/>
# Intro	<input type="text" value="4"/>
Columns	<input type="text" value="2"/>
# Links	<input type="text" value="4"/>
Category Order	<input type="text" value="No, order by Primary Order only"/>
Primary Order	<input type="text" value="Frontpage Ordering"/>
Pagination	<input type="text" value="Auto"/>
Pagination Results	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show

Компонентийн бичлэгийн холбоос (**Link - Component Item**) vvcгэсэн бол харин шууд APPLY юмуу SAVE товчыг дараад гарч болно. Энэ холбоосны параметрийн тохиргоо нь оригиналь холбоосныхыгоо ашиглана гэдгийг бид өмнө vзсэн.

Тавдугаар хэсэг: Нvvр хуудасны компонент

Цэсийн элементийн параметрийг доорх тохиргоонуудыг ашиглан оруулна:

Доорх параметрийн тохиргоонуудын олонхи нь бусад мэдээлэл, цэсийн элементvвдийнхтэй адилхан учир Нvvр хуудасны компонентийнг ашиглахгvй ч байсан эдгээрийг гvйлгээд харахад илvvдэхгvй болов уу:

1. Эдгээр тохиргоонуудын дотроос нэлээдгvй нь Глобал тохируулгад (Site > Global Configuration) заагдсан глобал тохиргоотой хамааралтай
2. Энд таны тохируулсан зvйлс мэдээний бичлэгvвдийн дээр нь байрлах Хуудасны дизайнд нелеелэх болохоос нэгж бие даасан мэдээний бичлэгэд хамаагvй
3. Зєвхєн єєрийн параметрийн тохиргоон дээрээ “Нvvр хуудасны” гэж заагдсан мэдээний бичлэгvвд л энэ хуудсан дээр гарч ирэн, энэ тохиргооны дагуу форматлагдана.

Parameters	
Menu Image	<input type="text" value="- Do not use an image -"/>
Page Class Suffix	<input type="text"/>
Page Title	<input type="text"/>
Page Title	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Back Button	<input type="text" value="Hide"/>
<hr/>	
# Leading	<input type="text" value="1"/>
# Intro	<input type="text" value="4"/>
Columns	<input type="text" value="2"/>
# Links	<input type="text" value="4"/>

Menu image (цэсийн зураг): А. Эхлээд холбоосныхоо баруун юмуу зvвн талд гарч ирж харагдах зургийг сонго. Энэ зураг /images/stories фолдер дотор байх ёстой.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Б. Модуль цэсээс, **Modules > Site Modules > Select the Active Link for your Menu Module** гэж ороод, модулийн параметрийн секцт **“Show Menu Items”** гэж байгааг **“Yes”** болгоно.

Page Class Suffix: хуудсанд нэмэлт стайл (CSS style) оруулна. Энд оруулсан suffix хуудасны CSS классууд дээр автоматаар нэмэгдэх юм. Гэхдээ vvp-ийг ашиглахын тулд вебийн загварын CSS stylesheet файл дотор vvp-ийг оруулж өгсөн байх шаардлагатай. Энэ талаар ойлгомжгvй зvйл гарвал программистаасаа асууна уу.

Page title: Хуудасны дээд секцт гарч ирэх хуудасны гарчиг текстийг оруулна уу

Show/hide page title: дээд секц дэх гарчиг текстийг харуулах эсэх

Back button: Хуудасны доор “буцах” товчлуурыг харуулах эсэх. Энэ нь хэрэглэгчдийг дарвал өмнө нь vзэж байсан хуудсанд нь буцаан аваачдаг.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

#Leading: Хуудсан дээр гарах гол мэдээний бичлэгvвдийн тоог оруул. Дэлгэцэн дээр гарах мэдээний товч нь мэдээний бичлэгийн “мэдээний товч” (Intro) тохируулган дээр оруулсан хэсэг текст болох юм.

#Intro: Мэдээний товчтойгоо хамт гарч ирэх бичлэгvвдийн тоог оруул.

#Columns: Мэдээний товчийг гаргахад шаардлагатай гэж vзэж буй багануудынхаа тоог оруул

#Links: Мэдээний товчгvйгээр, зvгээр холбоос маягаар гарч ирэх мэдээний бичлэгvвдийн тоог оруул. Гол бичлэгvвд болон товч хувилбартай мэдээнvвдийн доор гарна.



The screenshot shows a settings panel with four sections:

- Category Order:** A dropdown menu set to "No, order by Primary Order only".
- Primary Order:** A dropdown menu set to "Frontpage Ordering".
- Pagination:** A dropdown menu set to "Auto".
- Pagination Results:** Two radio buttons, "Hide" (unselected) and "Show" (selected).

🔗 **Category order** (Категориор эрэмблэх): Хэрвээ хэд хэдэн категорийн мэдээний бичлэгийг нэг хуудсанд харуулж байгаа бол тэгдээр нь эхлээд категориороо, дараа нь vндсэн эрэмбээрээ (доорх vндсэн эрэмбийн талбар дээр зааж өгсөн байдлаар) эрэмблэгдэх боломжтой. Доорх хувилбаруудаас сонгоно уу:

No, order by primary ordering only: Категорийн дэс дарааг хамааралгvйгээр бvгдийг нь vндсэн эрэмбээр эрэмблэх

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

Title alphabetical: Эхлээд категорийн нэрийн дарааллаар А-Я хүртэл эрэмблээд, дараа нь vндсэн эрэмбийг ашиглах

Title reverse-alphabetical: Эхлээд категорийн нэрийн дарааллаар Я-А хүртэл эрэмблээд, дараа нь vндсэн эрэмбийг ашиглах

Ordering: Эхлээд категорийн удирдлагын секцт байгаагаар нь категориудыг эрэмблээд, дараа нь vндсэн эрэмбийг ашиглах

☞ **Primary order** (vндсэн эрэмбэ): Мэдээний бичлэгvүдийн дэс дарааг тохируулна. Дээрх категорийн эрэмб эхлээд ордогийг анхаарна уу

Default: Нvвр хуудасны удирдлагын секцт тохируулсан дарааллаар оруулах

Frontpage ordering: Нvвр хуудасны удирдлагын секцт байгаа дарааллаар нь оруулах

Oldest first: Оруулсан огноогоор нь хамгийн эхэнд оруулсаныг нь эхэнд нь оруулах

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

Most recent first: Оруулсан огноогоор нь хамгийн сvвлд оруулсаныг нь эхэнд нь оруулах

Title alphabetical: Гарчигийнх нь нэрсийн дарааллаар А-Я хvртэл оруулах

Author alphabetical: Оруулсан хvмvвсийнх нь нэрсийн дарааллаар А-Я хvртэл оруулах

Author reverse-alphabetical: Оруулсан хvмvвсийнх нь нэрсийн дарааллаар Я-А хvртэл оруулах

Most hits: Vзсэн тоогоор нь эрэмблэх, хамгийн олон vзсэнийг нь эхэнд нь

Least hits: Vзсэн тоогоор нь эрэмблэх, хамгийн бага vзсэнийг нь эхэнд нь

↻ Pagination: Хуудасны дугаарыг доор нь гаргах эсэх, автоматаар дугаарлах эсэхийг тохируулна. Нvvp хуудсанд байгаа бусад хуудсууд руу хандсан холбоосуудыг харуулна (<< Start < Prev 1 2 Next > End >> гэдэг шиг)

Тавдугаар хэсэг: Нvvр хуудасны компонент

☞ **Pagination results:** Тооллогын vр дvнг vзvvлэх эсэх (нэг хуудсан дээр гарч ирсэн мэдээний тоо: 6 мэдээний 1-6-г харуулж байна гэдэг шиг)

<u>MOSImages</u>	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
<u>Section Name</u>	<input checked="" type="radio"/> Hide <input type="radio"/> Show
<u>Section Name Linkable</u>	<input checked="" type="radio"/> No <input type="radio"/> Yes
<u>Category Name</u>	<input checked="" type="radio"/> Hide <input type="radio"/> Show
<u>Category Name Linkable</u>	<input checked="" type="radio"/> No <input type="radio"/> Yes
<u>Item Titles</u>	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
<u>Linked Titles</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Read More</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Item Rating</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Author Names</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Created Date and Time</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Modified Date and Time</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>PDF Icon</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Print Icon</u>	<input type="text" value="Use Global"/>
<u>Email Icon</u>	<input type="text" value="Use Global"/>

☞ **MOSImages:** MOSImage-ийг vзvvлэх эсэх. (мэдээгээ оруулахдаа энэ хэрэгслийг ашигласан тохиолдолд)

☞ **Section Name:** Мэдээний эх секцийн нэрийг гаргах эсэх. Хэрвээ гаргахаар сонгох юм бол мэдээ бүрийн гарчигний дор эх секцийн нь нэр харагдана.

☞ **Section Name Linkable:** Мэдээний эх секцийн нэрийг гаргахдаа тэр секц руу хандсан холбоостойгоор гаргах. Зөвхөн дээр “гаргана” гэж сонгосон тохиолдолд харагдана.

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

☞ **Category Name:** Мэдээний эх категорийн нэрийг гаргах эсэх. Хэрвээ гаргахаар сонгох юм бол мэдээ бүрийн гарчигний дор эх категорийн нь нэр харагдана.

☞ **Category Name Linkable:** Мэдээний эх категорийн нэрийг гаргахдаа тэр категори руу хандсан холбоостойгоор гаргах. Зөвхөн дээр “гаргана” гэж сонгосон тохиолдолд харагдана.

☞ **Item titles:** Мэдээний гарчигийг харуулах эсэх

Доорх тохируулгууд өмнө нь Глобал тохируулган дээр ямар нэг байдлаар тохируулагдсан байгаа боловч энд тийм\үгвй гэж оруулсан байдал нь тэр тохируулгын утгыг бүх нvvp хуудсан дээр гарсан мэдээнvүдийн хувьд өөрчлөнө. Гэхдээ глобал тохируулгууд хэвээрээ үлдэж, бусад хуудсууд дээр тэр чигээрээ үйлчилнэ шvү дээ.

☞ **Linked titles:** Мэдээний гарчигийг мэдээний бүрэн хувилбар руу хандсан холбоос болгоно

☞ **Read more:** Цааш нь унших гэсэн холбоосийг мэдээний товчын дор гаргах эсэх

Тавдугаар хэсэг: Нvvp хуудасны компонент

☞ **Item Rating:** Уншигчдын өгсөн чансааг мэдээ бүрийн дор харуулах эсэх

☞ **Author Names:** Мэдээг оруулсан хvний нэрийг гаргах эсэх

☞ **Created date and time:** Мэдээний оруулсан он сар өдөр цагийг харуулах эсэх

☞ **Modified date and time:** Мэдээг хамгийн сvүлд зассан он сар өдөр цагийг харуулах эсэх

☞ **PDF Icon:** Мэдээний PDF хувилбарыг гаргах товчыг харуулах эсэх

☞ **Print icon:** Мэдээний хэвлэхэд тохиромжтой хувилбарыг гаргах товчыг харуулах эсэх


☞ **Email icon:** Мэдээг и-мэйлээр илгээх товчыг харуулах эсэх


Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

6.0 Санал асуулгын компонент, модулийг ашиглан хэрэглэгчийн санал асуулга хийх

Бид секц, категори, бичлэг гэсэн мэдээний төрлүүд шинэ мэдээний модультай хэрхэн зохицож ажилладагийг үзлээ. Модулиудтай зохицон ажилладаг еер олон төрлийн мэдээний төрлүүд, компонентүүд бий. Үүний нэг жишээ нь Санал асуулгын компонент, Санал асуулгын модуль юм.


Цэсээс орох зам: **Components > Polls**



Гарч ирсэн **Poll Manager** цонхны баруун дээд талаас  **New** товчийг дарж Санал асуулга үүсгэх хүснэгтийг гаргаж ирнэ

Тавдугаар хэсэг: Нvвр хуудасны компонент

Poll: New цонх:



Title талбар дээр санал асуулгынхаа асуултыг (мен нэр нь болж өгнө) оруулж өгнө.

Options хэсэгт байгаа 1-12 хүртэлх талбаруудад санал асуулгынхаа асуултад тохирсон 12 хүртэлх сонголтот хариулт оруулж өгөх боломжтой.

Show on Menu Items хэсгээс та санал асуулгаа тавихыг хүссэн хуудаснуудаа сонгох юм. Нэгээс олон хуудас сонгохын тулд гарныхаа CTRL товчыг ашигладаг гэж бид дээр үзсэн. Товчин дээрээ дараад, хуруугаа салгалгвйгээр хуудасны нэрүүд дээр дарна.




Save товчийг дарж санал асуулгаа хадгална. **Poll Manager** дээрх **Published** баганаас чагтыг дарж веб дээр тавина.

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент**6.1 Веб дээрээ санал асуулга идэвхжүүлэх**

Дараагийн ээлжинд бид хийсэн санал асуулгаа санал асуулгын модультай холбох хэрэгтэй.

Санал асуулгын модуль маань санал асуулгын компонентоор дамжуулан асуулгатай холбогддог юм. Энэ модуль таны асуулгад оруулсан бичлэгүүдийг аваад, өмнө нь сонголт хийх чагт байрлуулаад, дараа нь хүмүүсийн саналыг цуглуулах үүрэгтэй. Энэ үеэр таны санал асуулга веб дээр тавигдсан **(Published)** байлаа ч модуль нь тавигдааггүй бол асуулга сайтын зочидод харагдахгүй хэвээрээ байха болно.

Модулийг веб дээр тавихын тулд цэсээс **Modules > Site Modules** гэдгийг сонгоорой:



Энд байгаа модулиудын жагсаалтаас **“Санал асуулгын модуль”** (таны сайт дээр **“Санал асуулга”, “Polls”, “Polls Module”** гэх мэт нэрүүдээр байж болно) гэдгийг хайж олоод, **Published** гэсэн багана дээр **✗** байвал дээр нь дарах хэрэгтэй.

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

6.2 Санал асуулгын модулийн веб дээрх байршлыг тохируулах

Module Manager (Modules > Site Modules) цонхноос санал асуулгын модуль дээр дарна уу.

Модулийн тохиргоог **Site Module: Edit** цонхноос өөрчилнэ. Энд **Module Details** (зүүн талынх нь), **Pages/Items** (баруун талынх нь, гарч ирэх хуудсан дээрх байршилийн тохиргоо) хоёрыг анхаарна уу:

The screenshot shows the Joomla! administration interface for editing a site module. The breadcrumb trail is Home > Site > Menu > Content > Components > Modules > Mambots > Installers > Messages > System > Help. The URL is Joomla! / com_modules / editA. There are 'Preview' and 'Save' buttons in the top right.

The main content area is titled 'Site Module: Edit [Санал асуулга]' and is divided into two panels:

- Details:**
 - Title: Санал асуулга
 - Show title: Үгүй Тийм
 - Position: right
 - Module Order: 1::Санал асуулга
 - Access Level: Public
 - Published: Үгүй Тийм
 - ID: 1
 - Description: This module compliments the Polls component. It is used to display the configured polls. The module differs from other modules in as much as the Component supports linking between Menu Items and Polls. This means that the module shows only those Polls, which are configured for a certain Menu item.
- Pages / Items:**
 - Menu Item Link(s):
 - All
 - None
 - Unassigned
 - mainmenu | Нүүр хуудас
 - mainmenu | МАУС! -н лиценз
 - mainmenu | Мэдээ
 - mainmenu | Шинэ мэдээ
 - mainmenu | Мэдээллийн самбар
 - mainmenu | Холбоосууд
 - mainmenu | Холбоо барих
 - mainmenu | Хайлт
 - mainmenu | News Feeds
 - mainmenu | FAQ's
 - mainmenu | Wrapper
 - othermenu | МАУС! -н вебсайт
 - othermenu | МАУС! -н хэл лүүлэг
 - othermenu | МАУС! -г хөгжүүлэгчид
 - othermenu | Администатор
 - topmenu | Нүүр хуудас
 - usermenu | Your Details

Below the details panel is the **Parameters** section:

- Enable Cache: No Yes
- Module Class Suffix: []

Энд дандаа бидний өмнө ярилцсан, мэдэх тохируулгууд байгааг та харж байна. Деталийн хэсгээс та Модулийнхаа нэрийг өөрчилж болно. **Position** гэсэн талбараас та санал асуулга гарч ирсэн хуудасныхаа чухам аль хэсэгт нь гарахыг тохируулах боломжтой. Яг ийм тохиргоог бид өмнө нь өөр модулийн байршлыг тохируулах тухай үзэж байхдаа ашиглаж байсан билээ. Эдгээр байршлууд нь хуудасны чухам аль аль хэсэг болохыг мэдэхийн тулд нэг нэгээр нь сонгон туршиж үзээрэй.

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

6.3 Модулийн тохиргоог өөрчлөх - Деталь, хуудасны тохиргоо г.м



Site Module: Edit [Санал асуулга]

Details

Title: Санал асуулга

Show title: Үгүй Тийм

Position: right

Module Order: 1::Санал асуулга

Access Level: Public
Registered
Special

Published: Үгүй Тийм

ID: 1

Description: This module compliments the Polls component. It is used to display the configured polls. The module differs from other modules in as much as the Component supports linking between Menu Items and Polls. This means that the module shows only those Polls, which are configured for a certain Menu Item.

Title: Санал асуулгын модулийн нэр. Энэ нэр нь веб дээр санал асуулгын дээхнэ талд харагдана. **“Санал Асуулга”** ч гэдиймуу, ямар нэг тохиромжтой нэр сонгож өгөх хэрэгтэй.

САНАЛ АСУУЛГА

МАУС! ашиглан веб сайтаа бүтээхэд....

Маш хялбархан

Бусадтай л адил

Хэтэрхий төвөгтэй

Ok **Үр дүн:**

Show title: Санал асуулгын модулийн нэр веб дээр харагдах эсэхийг тохируулна


Position: Санал асуулгынхаа модулийн байршлыг зааж өгнө. Веб хуудасны баруун, зүүн талд, доор нь гэх мэт

Module order: Бусад модулиудтай ямар эрэмбээр дараалагдан гарч ирэхийг заана

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

Published: Тийм гэж сонговол шууд веб дээр тавигдана. Дараа тавъя гэвэл “Үгүй” гэдгийг сонгоорой

Хуудас\бичлэгийн тохируулга - модуль маань аль аль хуудсууд дээр тавигдах вэ?



Санал асуулгаа дээр нь гаргахыг хвссэн бүх холбоосыг (уг холбоосын хандсан хуудас гэсэн үг) идэвхжүүлнэ үү. Цаанаасаа бүх хуудсан дээр гарч ирэхээр тохируулагдсан байгаа. ТАУС! хуудаснуудыг биш, тэдэн рүү чиглэсэн холбоосыг л “хардаг” гэж дээр үзсэнийг бүү мартаарай. Тиймээс та модулиа веб дээр тавигдсан хуудсууд руу биш тэдний холбоосууд руу оруулж өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл та санал асуулгаа хуудсан доторх мэдээлэлд биш, уг хуудас руу хандсан цэсийн элементтэй холбож өгч байгаа хэрэг.


Дууссаныхаа дараа



Save товчыг дарж хийсэн зүйлсээ хадгална.

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

Доорх вебсайт дээр санал асуулга яаж гарч ирсэн байгааг үзнэ үү:



Санал асуулга маань Сайтын аль нэг хэсэгт гарч ирэхээр тохируулагдсан Санал асуулгын модуль дотор “амьдардаг”. Санал асуулгын модулийг сайтны баруун хэсэгт гарч ирэхээр тохируулсан учраас хэрэглэгчийн санал асуулга маань тэнд гарч байгаа юм шүү дээ.

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

Модуль, компонент хоёрын ялгаа юу вэ?

Модуль: Динамик мэдээ, мэдээллийг веб сайтын аль нэг секцт гаргаж харуулах боломж олгодог нэмэлт программ. Жишээ нь санал асуулгын модуль нь санал асуулгын компонентоор хийгдсэн асуулгыг веб дээр гаргаж тавих боломж олгоно.

Компонент: Биеэ даасан функционал программ. Ихэвчлэн модультай байжээж үр дүн нь веб дээр харагдана.

Дэлгэрэнгүй тайлбарлъя:

Санал асуулгын модуль, компонент хоёр хамтран ажилладаг - хэрвээ та компонент дотор цэсийн элемент рүү хандсан холбоос үүсгэсэн бол энэ хуудсыг (цэсийн элементийг) модуль дотор ч бас оруулж өгөх ёстой болно.

Жишээ:

А. Санал асуулгын компонент-д та “хэрэглээний санал асуулга” үүсгээд, үүнийгээ нүүр хуудас БА харилцах хаягны хуудас хоёр руу холбосон байж гэе. Үүнийхээ дараа та модулийн удирдах секцт очоод санал асуулгын модулийг нүүр хуудастай холбож өгнө.

Үр дүн нь: “хэрэглээний санал асуулга” маань харилцах хаягны хуудсан дээр харагдахгүй, учир нь үүнийг агуулж байгаа зүйл болох санал асуулгын модуль маань энэ хуудастай холбогдоогүй шүү дээ. Ойлгомжтой болж байна уу?

Зургадугаар хэсэг: Санал асуулгын компонент

Б. Санал асуулгын компонент-д та “хэрэглээний санал асуулга” үүсгээд, үүнийгээ Зөвхөн нүүр хуудас руу холбосон байж гэе. Үүнийхээ дараа та модулийн удирдах секцт очоод санал асуулгын модулийг нүүр хуудас БА харилцах хаягны хуудастай холбосон байг.

Үр дүн нь: “хэрэглээний санал асуулга” маань нүүр хуудас дээр модулийнхаа дотор (модуль гэдэг маань компонент буюу манай жишээн дээр санал асуулгын “хадгалагч” гэдгийг санаарай) хэвийн харагдах боловч харилцах хаягны хуудсан дээр хоосон санал асуулга л харагдах болно, учир нь “хэрэглээний санал асуулга” маань зөвхөн нүүр хуудастай холбогдсон шүү дээ.

Хялбархан байгаа биз!

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо

7.0 Шинэ хэрэглэгч нэмэх

Цэсээс очих зам: [Site](#) > [User Manager](#)

[User Manager](#) цонхноос [New](#) товчыг даран шинэ хэрэглэгч нэмэх цонхонд очино.

[User: Add](#) цонх:

The screenshot shows the Joomla! User Manager interface for adding a new user. The page title is "User: Add". The form is divided into two main sections: "User Details" and "Parameters".

User Details:

- Name:
- Username:
- Email:
- New Password:
- Verify Password:
- Group: A dropdown menu with the following options: Public Frontend, Registered, Author, Editor, Publisher, Public Backend, Manager, Administrator, Super Administrator.

Parameters:

- User Editor:

Contact Information:

No Contact details linked to this User.
See 'Components -> Contact -> Manage Contacts' for details.

At the bottom left, there is a "Block User" checkbox and two radio buttons: "Үгүй" (selected) and "Тийм" (Yes).

1. **Name** талбарт: Шинэ администраторынхаа нэрийг оруулна
2. **Email** талбарт: Шинэ администраторын и-мэйл хаягийг оруулна
3. **Username**: Шинэ администраторын хэрэглэгчийн нэрийг оруулна (сайтад нэвтрэхэд хэрэглэх)
4. **New password/Verify password** талбарт нууц үгээ хоёр дахин оруулна.
5. **Group** талбараас **-Administrator**-ыг сонгон шинэ администратор үүсгэнэ. Эндээс өөр ямар түвшний хэрэглэгч болохыг нь сонгож өгөх боломжтой.



Save товчыг дарж шинэ хэрэглэгчээ нэмнэ.

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо

Хэрэглэгчийн твшиний талаар дэлгэрэнгүй авч үзье:

ТАУС-д хоёр янзын үндсэн хэрэглэгчийн твшин байна. Эхнийх нь хэрэглэгчийн интерфэйс дээр ажиллах эрхтэй (Public Frontend), хоёр дахь нь сайтын удирдлагын хэсэгт нэвтрэн ажиллах эрхтэй байна (Public Backend).

Public Front-end

- | - Registered
- | - - Author
- | - - - Editor
- | - - - - Publisher

Public Back-end

- | - Manager
- | - - Administrator
- | - - - Super Administrator

Front-End:

Registered гэдэг нь сайтын бүртгэлтэй хэрэглэгч бөгөөд зөвхөн бүртгэлтэй хэрэглэгчидэд зориулсан (олон янзын мэдээлэл оруулахдаа тэдгээрт хандах эрхтэй хэрэглэгчийн твшинг оруулж өгөх боломжтой байсныг та санаж байгаа байхаа) мэдээлэлд хандах эрхтэй юм.

Author гэдэг нь вебсайт дээр мэдээ, мэдээлэл оруулах эрхтэй хүн

Editor гэдэг нь вебийн удирдлагын хэсэг рүү нэвтрэлгүйгээр наана хүмүүсийн оруулсан мэдээ, мэдээллийг засч янзалах, устгах, нэмэх эрхтэй хүнийг хэлнэ.

Publisher гэдэг нь Editor-ын бүх эрхийг эдлэхээс гадна мэдээ, мэдээллийг веб дээр тавих, тавихгүйг шийдэх эрхтэй хүн.

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо**Back-End:**

Super Administrator нь сайтын бүх тохиргоог өөрчлөх эрхтэй. Таны сайт дор хаяж нэг Super-Administrator-ын эрхтэй хэрэглэгчтэй байх ёстой. Тэгэхгүй бол Глобал тохируулгыг өөрчлөх эрхтэй өөр хэрэглэгч байхгүй юм. Энэ бүлгийн хэрэглэгчийг бусад бүлгийн хэрэглэгчид устгаж, өөрчилж чадахгүй.

Administrator нь дээрхийг бодвол арай бага эрх мэдэлтэй. Тэд

- Super Administrator-уудыг устгаж, өөрчилж
- Глобал тохируулгыг өөрчилж
- Масс мэйлийн функцыг ашиглаж
- Сайтын загвар (template) суулгаж, өөрчилж
- Шинэ хэлний файл суулгаж, өөрчилж чадахгүй, бусдыг нь хийх эрхтэй

Харин **Manager** нь удирдлагын хэсэгт нэвтрэх эрхтэй боловч ерөнхийдөө сайтын мэдээ, мэдээлэлийн хэсгийг хариуцах үүрэгтэй хэрэглэгч юм. Тэд нь

- Хэрэглэгчдийн устгаж, нэмж, өөрчилж
- Модуль суулгаж
- Компонент суулгаж
- Зарим компонент-д (Super Admin-ий зааж өгсөн) хандаж чадахгүй юм.

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо

- ✓ Шинэ администраторууд хамгийн анх сайтад нэвтрэхдээ веб сайтын URL рvv очих болно. Эндээс ТАУС!-ын удирдлагын секцт нэвтрэх боломжгvй байж болох учир тэдэнд удирдлагын секцт очих URL-ийг хэлж өгөхөө мартуузай. Ихэнх тохиолдолд сайтын хаягны араас /administrator гэж нэмсэн байдалтай байдаг.
- ✓ Админууд вебийн энгийн нvvрэн дээр байгаа нэвтрэх модулиас* шууд хэрэглэгчийн нэр, нууц vгээ ашиглан нэвтрэх боломжтой.

* нэвтрэх модуль нь веб дээр тавигдсан байх юм бол танай вебийн хэрэглэгчийн тусгай эрх шаарддаг хэсгvvдэд тэдгээр тусгай эрхтэй хэрэглэгчид нэр, нууц vгээ ашиглан нэвтрэх боломжийг олгоно.

Нэвтрэх модулийг веб дээрээ тавин, олон янзын хэрэглэгчийн эрхийн тvвшинг бий болгосноор та бүртгvvлсэн хэрэглэгчиддээ сайт дээр мэдээлэл өөрсдөө нэмэх, зөвхөн тэдэнд зориулсан тусгай мэдээлэл оруулах боломжтой болох юм. Vүнээс гадна, админы хувьд та уг модулиар нэвтрэснийхээ дараа сайт дээрээсээ зарим зvйлсийг (ТАУС!-ын удирдлага руу оролгvйгээр) засах боломжтой болно.


Ухаандаа та нэвтрэх модулийг ашиглан хэлэлцvvлэг рvvгээ зөвхөн уг модулиар нэвтрэсэн, бүртгvvлсэн хэрэглэгчдийг л оруулах маягаар ашиглаж болох юм.

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо

7.1 Сайтын хэрэглэгчийн тохиргоог өөрчлөх

Цэснээс орох хаяг: [Site > User Manager](#)


User Manager цонх:



Тохиргоог нь өөрчлөхыг хвссэн хэрэглэгчийнхээ нэрийн өмнөх дөрвөлжинд



тэмдэглээд **Edit** товчыг даран **User: Edit** цонхыг нээнэ:



- Name:** Нэрийг нь өөрчлөх
- Email:** И-мэйлийг нь өөрчлөх
- Username:** Хэрэглэгчийн нэрийг нь өөрчлөх
- New password:** Шинэ нууц үг оруулах
- Verify password:** Шинэ нууц үгээ дахин оруулах



Өөрчлөлтийг хийснийхээ дараа **Save** товчыг даран хадгална.

Долдугаар хэсэг: Хэрэглэгч, администраторуудын тохиргоо**7.2 Хэрэглэгч устгах**

Цэснээс орох хаяг: **Site > User Manager**

Эндээс та устгахыг хүссэн хэрэглэгчийнхээ нэрний урд сонгоод, дээр байгаа



Delete товчыг дарна. Устгахдаа итгэлтэй байгаа эсэхийг асуусан цонх гарч ирэхэд нь ОК дарснаар уг хэрэглэгч устгагдах болно.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

8.0 Зураг нэмэх - Медиа менежерийг хэрхэн ашиглах тухай

Медиа менежер сайтын хэрэглэгчдэд шинэ зураг болон өөр олон төрлийн файлуудыг сайт руу оруулах боломж олгоно. Мөн фолдер ашиглан файл, зурагнуудаа цэгцтэй байлгах боломжтой.

Медиа менежерийн талаар:


Энэ нь зургийн болон бусад файлууд хадгалагддаг газар учраас жишээлбэл та мэдээ оруулах хэсгээс та Insert Image товчыг дарах юм бол тэр нь Медиа менежер рүү орон, тэнд байгаа зургуудаас оруулах болно.

Вебэд суурилсан олон програмууд дээр та нэг зүйлийг олон янзаар хийж боломжтой байдаг. Жишээ нь дээрх Insert Image товчыг дарснаар та өөр төрлийн файл биш зөвхөн зураг оруулах боломжтой бол өөр файл оруулахын тулд та Медиа менежерийг ажиллуулах хэрэгтэй.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер


8.1 Медиа менежер рүү файл хуулах

Цэснээс орох хаяг: Site > Media Manager



Файл хуулахын тулд **Browse** товчин дээр дараад файл сонгох цонхыг гаргаж ирнэ.

Файлынхаа байгаа фолдерыг идэвхжүүлээд **Open** товчыг даран нээнэ. Үүний дараа хуулах файлаа идэвхжүүлээд **Upload** товчыг даран Медиа менежер рүү файлаа хуулна.





8.2 Файлуудаа эмх цэгцтэй байлгахын тулд фолдер үүсгэх нь

Create Directory талбар дээр шинэ фолдерийнхоо нэрийг бичиж өгөөд



Create товчыг дарж шинэ фолдер үүсгэнэ.



Файл устгахын тулд Медиа менежерийн цонхон дээр файлын доор байгаа хогийн савны зурагтай  **Trash** товчыг ашиглана. **Code** талбарт зурагнахаа URL буюу хаягийг оруулахын тулд үзэгний зурагтай  товчыг ашиглана. Зургийн файл дээр даргах нь мөн **Code** талбарт зурагны хаягийг оруулна. Энэ кодийг дараа нь хуулж аваад текст юмуу зурган холбоосны ард оруулах боломжтой

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

Медиа менежер дээр файльтай ажиллах талаар нэмэлт:

.jpg, .gif гэх мэт зургийн файлуудаас гадна .doc, .xls, .ppt гэх зэрэг өөр төрлийн файлуудыг ч Медиа менежер рvv оруулах боломжтой. Зургаас өөр файл оруулах болвол программистаасаа зөвлөгөө авна уу.


Файлын нэрэнд зай аваад хэрэггvй байдаг. Зайны оронд доогуур зураас () ашиглвал дээр

Фолдерууд ашиглан ижил төстэй зургуудыг цэгцтэй байлгах нь танд бvх зургаа Медиа менежер дээр шавааралдуулахаас хамаагvй амар байх болно.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

8.3 Веб хуудсанд хялбар засварлагч ашиглан зураг буюу баримт оруулах



Хялбар засварлагч (**WYSIWYG Editor** What you see is what you get) нь ТАУС!-д зориулагдсан интернэтээс татаж авах боломжтой “мамбот” юм. Бидний ашиглах засварлагчийн нэр нь **mosCE**. Үүний тусламжтайгаар та Медиа менежерт байгаа зургуудад Insert Image товчийг даран хандах боломжтой болно.



Хялбар засварлагчаас модны зурагтай товчыг даран зургийн менежер рvv орно. Эндээс та мэдээндээ зураг оруулах, эсвэл компьютерээсээ зургийн менежер рvv файл оруулах боломжтой.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

Мэдээндээ зураг оруулахын тулд та зургаа оруулахыг хвссэн газраа хулганыхаа гол заалтуурыг аваачаад, дээрх модны зурагтай товчыг дарна. Зургийн удирдлагын цонхноос хвссэн файлынхаа URL-ыг оруулна. Зургын URL буюу хаягийг хэрхэн Медиа Менежерийн **Code** талбар дээр гаргадгийг бид дээр үзсэн.



“Appearance” хэсэг дэх тохируулга нь зурагаа тойруулаад хоосон зай бий болгох, эсвэл хүрээ зурах, зургаа хуудасны хаана оруулах(текстийн баруун, эсвэл зүүн талд) зэрэг олон янзын нэмэлт тохиргоог хийж өгөх боломж олгодог. Зургийн хүрээ, эсвэл зургийг тойрсон хоосон зайны өргөн нь пикселээр хэмжигдэнэ. Хоосон зай орхиход босоо зай, хэвтээ зай гэсэн 2 янзын тохиргоо байна.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

Path	Зургийн файлыг идэвхжүүлсний дараа автоматаар гарч ирнэ. Веб дээрх зурагны хаяг болох юм
Alternative text	Зочин энэ зурган дээр хулганыхаа заалтуурыг авчирахад гарч ирэх жижиг текст. Зурагныхаа юу үзүүлж байгааг тайлбарласан товч зүйл бичээд өгчихвөл хараа муутай хүмүүс ч юм уу, браузер дээрээ зураг гаргахгүйгээр тохируулсан хүмүүс юун тухай зураг болохыг нь ойлгоход дөхөмтэй болно.
Dimensions	Зургийн файлыг идэвхжүүлсний дараа автоматаар гарч ирнэ. Үүнийг өөрчлөсний хэрэггүй
Dimensions 2 V	Зургийн файлыг идэвхжүүлсний дараа автоматаар гарч ирнэ. vнийг өөрчлөсний хэрэггүй
Alignment харьцангуй	Зургийнхаа яаж байршахыг зааж өгнө: Энэ нь тексттэй хамааралтай

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

Vertical space Босоо тэнхлэгийн дагуу зураг, текст хоёрынхоо хооронд зай оруулах бол энд утгыг нь бич. Энэ хоёр хоорондоо ямар ч зайгвй байвал хvн ялгаж харж уншихад ч хэцvv, харахад ч онцгvй байх болов уу.

Horizontal space Босоо тэнхлэгийн дагуу зураг, текст хоёрынхоо хооронд зай оруулах бол энд утгыг нь бич. Энэ хоёр хоорондоо ямар ч зайгвй байвал хvн ялгаж харж уншихад ч хэцvv, харахад ч онцгvй байх болов уу.

Border Зурагтаа хврээ оруулах бол энд ергенийх нь утгыг оруул.
Сvvлийн 3 утга пикселээр гэдгийг дээр хэлсэн

Наймдугаар хэсэг: Медиа Менежер

Зургийн файл ба интернэт гэдэг нэлээн урт нэмэлт:

1. Файлын хэмжээ - 3mb ба 12К, аль нь вэ?

Та удахгүй ихэнх зургууд веб дээр тавихаасаа өмнө хэмжээг нь багасгахгүй бол хэтэрхий том болохыг ойлгоно. Зургийн файлыг веб дээр тавихын тулд тэр нь жинхэнэ хэмжээний хувьд ч, файлын хэмжээний хувьд ч хэт том биш байх шаардлагатай. Файлын хэмжээг багасгах нь түүнийг хэрэглэгч үзэхийн тулд татаж авахад шаардлагатай цагийг багасгах бөгөөд улмаар таны сайтыг “хурдан” ачаалдаг болоход нэмэр болох юм.

Зургийн файлын хэмжээг багасгахын тулд Photoshop, Fireworks гэх мэт зургийн программуудыг ашиглана. Үүнд 2 үндсэн алхам бий:

1. Зургийнхаа жинхэнэ хэмжээг өндөр, өргөнийх нь пикселийг ашиглан багасгах
2. JPG форматаар хадгалах.

Ихэнх веб браузерын уншиж чаддаг стандарт формат нь JPG, GIF хоёр юм.

Өөр төрлийн зургийн форматтай (.pict, .psd, .tiff, .bmp, .eps гэх мэт) файлууд дээрх хоёрын аль нэг рүү нь хөрвүүлэгдсэн байх шаардлагатай. Үүнийг хийхэд дээрх программуудыг ашиглахад болно. Бас Gif өргөтгөлтэй файлыг Jpg болговол чанар нь алдагддагийг санаарай.

Наймдугаар хэсэг: Медиа Менежер**Ойлговол зохих зүйлс:**

Та зургийн хэмжээг жинхэнэ пикселээр нь багасгалгүйгээр зүгээр л захаас нь чирээд жижиг болгох юм бол хэмжээ нь яг хэвээрээ үлдэнэ шүү! Тэрнээс гадна ингэж чирж томруулж багасгах нь зургийг онцгүй харагдуулна гэдгийг санаарай. Таны веб дээр ийм зургууд байвал хүмүүст мэргэжлийн бус санагдана шүү дээ.

2. Хүрээ, зай

Зургаа медиа менежерээс оруулах үед та бусад тохиргооны дээр хүрээ, хоосон зай 2 нэмэх тохиргоо оруулах боломжтой болно гэдгийг бид дээр үзсэн. Ерөнхийдөө зургийг тойрсон хүрээ нэмэх нь ямар нэг гоо зүйн ч юмуу, дизайны өөрчлөлт оруулдаггүй. Өөрөө туршиж үзээд таалагдсанаараа хийнэ үү. Харин зураг, текст хоёрын хоосон зай нь арай чухал. Энэ тохиргоо хүрээтэй адид пикселээр хэмжигдэх бөгөөд та үүнд хэвтээ, босоо хоёр тэнхлэгийн утга оруулах боломжтой. Хэвтээ гэдэг нь зургийн дээд ба доод секц, босоо нь баруун зүүн секц шүү.


Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.0 Глобал тохиргоо

ТАУС-ын глобал тохиргоо нь **configuration.php** файл дээр хадгалагддаг бөгөөд ТАУС-гийн ажиллагааны зарчимын тохируулгыг зааж өгөх үүрэгтэй. Энэхүү тохиргоог өөрчилж, зааж өгөхийн тулд таны **configuration.php** файлын хандалтын зэрэг “өөрчлөлт хийх боломжтой” байх шаардлагатай байдаг. ТАУС анх суухдаа уг файлыг өөрчлөлт хийх боломжтойгоор тохируулсан байгаа тул танд санаа зовох зүйлгүй.

Глобал тохируулгыг өөрчлөхийн тулд ТАУС-ын удирдлагын самбарын дээд талын цэсээс доорх замаар орно уу:


Site > Global Configuration



Харин анх удаа тохируулгаа хийсний дараа файлын хандалтын зэргийн (**writable**: өөрчлөлт хийх боломжтой **unwritable**: өөрчлөлт хийх боломжгүй) хажууд “**make unwritable after saving**” гэсэн байгааг идэвхжүүлээрэй. Энэ нь таны **configuration.php** файлыг өөрчлөлт хийх боломжгүй болгох бөгөөд ийм болгож өөрчлөх нь таны сайтын аюулгүй байдалд тустай.


Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

Хэрвээ дараа нь глобал тохиргоогоо өөрчлөхийг хүсвэл файлынхаа хандалтын зэргийг дахин өөрчлөлт хийх боломжтой болгон өөрчлөх шаардлагатай. Хэрвээ таны сайт веб дээр тавигдчихсан бол FTP программ ашиглан файлын хандалтын эрхийг өөрчилж болно. FTP программаасаа сайтынхаа файлууд дундаас **configuration.php** файлаа хайж олоод (ТАУСгийн үндсэн хавтасанд дээр байдаг) **chmod** командаар 777 атрибутыг оноож өгөх хэрэгтэй. Тухайлбал FlashFXP программ дээр та файлынхаа нэр дээр хулганыхаа баруун товчыг дараад **“attributes (CHMOD)”** командыг сонгоод гарч ирсэн цонхны доод хэсэгт байгаа **“permissions”** талбарт 777 тоог бичиж өгөөд ОК дарах хэрэгтэй:



Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

За ингээд глобал тохиргооны хэсэг маань анх ороход иймэрхүү байдалтай харагдана:



The screenshot displays the Joomla! Global Configuration interface. At the top, there is a navigation menu with options: Home, Site, Menu, Content, Components, Modules, Mambots, Installers, Messages, System, Help. The current page is identified as 'Den of Joomla! / com_config'. On the right side, there are buttons for 'Save', 'Apply', 'Cancel', and 'Help', along with a 'Logout admin' link. The main heading is 'Global Configuration' with a sub-heading 'configuration.php is : Writeable' and a checkbox 'Make unwriteable after saving'. Below this, there are tabs for 'Site', 'Locale', 'Content', 'Database', 'Server', 'Metadata', 'Mail', 'Cache', 'Statistics', and 'SEO'. The 'Site' tab is active, showing various configuration options:


- Site Offline: Үгүй Тийм
- Offline Message:
- System Error Message:
- Site Name:
- Show Unauthorized Links: Үгүй Тийм
- Allow User Registration: Үгүй Тийм
- Use New Account Activation: Үгүй Тийм
- Require Unique Email: Үгүй Тийм
- Debug Site: Үгүй Тийм
- Default WYSIWYG Editor:
- List Length:
- Favourites Site Icon:

At the bottom, there is a small text: 'Joomla! is Free Software released under the GNU/GPL License.'

Энэ маань “Site”, “Locale”, “Content”, “Database”, “Server”, “Metadata”, “Mail”, “Cache”, “Statistics”, “SEO” гэсэн арван тохиргооны бүлэгтэй байгааг та харж байна. Бүгдээрээ одоо эдгээр бүлгүүдийг еэртээ ямар тохиргоо агуулсан байгааг нэг бүрээр нь авч үзье:

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.1 “Site” тохиргооны бүлэг:



The screenshot shows the Joomla! Global Configuration interface, specifically the 'Site' tab. The page title is 'Global Configuration' and it indicates 'configuration.php is : Writeable'. There is a checkbox for 'Make unwriteable after saving' which is currently unchecked. The 'Site' tab is selected, and other tabs include 'Locale', 'Content', 'Database', 'Server', 'Metadata', 'Mail', 'Cache', 'Statistics', and 'SEO'. The configuration options are as follows:

- Site Offline:** Radio buttons for 'Үгүй' (checked) and 'Тийм'.
- Offline Message:** Text area containing 'This site is down for maintenance.
 Please check back again soon.' with a help icon.
- System Error Message:** Text area containing 'This site is temporarily unavailable.
 Please notify the System Administrator' with a help icon.
- Site Name:** Text input field containing 'Den of Joomla'.
- Show Unauthorized Links:** Radio buttons for 'Үгүй' and 'Тийм' (checked).
- Allow User Registration:** Radio buttons for 'Үгүй' and 'Тийм' (checked).
- Use New Account Activation:** Radio buttons for 'Үгүй' and 'Тийм' (checked).
- Require Unique Email:** Radio buttons for 'Үгүй' and 'Тийм' (checked).
- Debug Site:** Radio buttons for 'Үгүй' and 'Тийм' (checked).
- Default WYSIWYG Editor:** Dropdown menu set to 'TinyMCE WYSIWYG Editor'.
- List Length:** Dropdown menu set to '30'.
- Favourites Site Icon:** Text input field containing 'favicon.ico' with a help icon.

Site Offline: Энэхүү тохиргоог “Тийм” дээр нь тависнаар таны вебийг хүмүүс орж үзэх боломжгүй болно. Түр хугацаанд шинэ модуль ч юмуу суулгах хоорондоо сайтдаа зочин хүлээж авахыг хүсэхгүй байгаа бол үүнийг ашиглах нь тохиромжтой. Харин түүнийхээ дараа энэ тохиргоогоо буцаагаад “Үгүй” болгож өөрчлөхөө мартуузай.

Offline Message: Дээрх тохиргоон дээр “Тийм” гэж сонгосон бол танай сайтад зочилохоор орсон хэрэглэгчид энэ талбарт байгаа текст харагдах болно. Энд та яагаад танай веб түр хугацаагаар ажиллахгүй болсон тайлбараа бичиж өгөх боломжтой.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

System Error Message: Хэрвээ ямар нэг өгөгдлийн сангийн түр зуурын алдаа, серверийн бага зэрэг гэмтлээс ч юмуу шалтгаалаад хэрэглэгч таны веб дээрх тодорхой нэг хуудасыг үзэж чадахгүй болсон тохиолдолд энэ талбар дээр байгаа текст гарч ирэх болно. Энд та юу хүссэнээ бичиж болох боловч ерөнхийдөө алдаа гарсанд уучлалт хүсээд, удахгүй энэ алдаа засагдах талаар найдаж байгаагаа илэрхийлсэн боловсон зүйл бичвэл зохино. Энд та стандарт HTML код ашиглан текстийнхээ форматыг өөрчлөх боломжтой.

Site Name: Таны сайтын нэр. Энэ нэр нь хэрэглэгчид таны сайт руу зочилж байх үед браузерийнх нь цонхны дээд талд гарч ирж харагдана. Сайтныхаа агуулга, зорилго чиглэлтэй уялдсан товч тодорхой нэрийг, богино тайлбартай хамт оруулна уу.

Show Unauthorized Links: Хэрвээ та энэ тохиргоог “Тийм” дээр нь тавих юм бол сайтад зочилж байгаа бүх хэрэглэгчид таны оруулсан бүх мэдээлэлд хандалтын зэрэгийг нь үл хамааран хандах эрхтэй болно. Өөрөөр хэлбэл уг нь зөвхөн бүртгэлтэй хэрэглэгчид үзэхээр зааж өгсөн (мэдээллийн хандалтын эрхийг хэрхэн тогтоохыг бид дээр үзсэн билээ), эсвэл зөвхөн админууд үзэхээр заасан мэдээллийг сайтад орсон бүх хэрэглэгч үзэх боломжтой болно гэсэн үг юм.

Allow User Registration: Энэ тохиргоо нь хэрэглэгчид өөрсдөө танай сайтад бүртгүүлэх боломжтой байх эсэхийг заана. Хэрвээ “Тийм” дээрээ байвал хэрэглэгчийн нэвтрэн орох хэрэглэгчийн нэр, нууц үгтэй талбарын доор таны “шинээр бүртгүүлэх” гэсэн нэмэлт холбоос гарч ирэх бөгөөд зочид энэ холбоосыг ашиглан танаар дамжуулалгүй өөрсдөө бүртгүүлэх боломжтой болно.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

Use New Account Activation: Энд “Тийм” гэж сонгосон байвал шинээр хэрэглэгч болохоор бүртгүүлсэн зочин хэрэглэгч болохынхоо өмнө и-мэйл хаягаар нь явуулсан “activation link” буюу идэвхжүүлэх холбоос дээр дарах шаардлагатай болно. Ингэх нь хэдийгээр хэрэглэгч болох явцыг удаашруулан, улмаар хүмүүсийн таны сайтад бүртгүүлэх хүслийг багасгах талтай боловч хүмүүс бүртгүүлэхийн тулд ямар ч байсан өөрийн ашигладаг нэг и-мэйл хаягийг оруулан, тодорхой хэмжээний цаг зарцуулахыг шаардаж байгаагаараа нэг хүн өөртөө хамаагүй олон данс үүсгэх, магадгүй автоматжуулсан программын бот таны сайтыг гацаах гэх мэтээс сэргийлэх тустай.

Require Unique Email: Энэ тохиргоо нь нэгээс олон хэрэглэгч нэг и-мэйлээр бүртгүүлэх эсэхийг заана. “Тийм” гэвэл нэг и-мэйл хаягаар нэгээс олон хэрэглэгч бүртгүүлж болохгүй.

Debug Site: Энэ тохиргоо танд сайтынхаа үйл ажиллагаатай холбогдон гарсан алдаануудын жагсаалтыг харах боломж олгоно. Сайтын ажиллагааны доголдол юундаа байгааг олж илрүүлэхэд энэ нь тун тустай.


Default WYSIWYG Editor: ТАУС-д суулгасан түргэн засварлагч программуудаас алийг нь сонгохоо сонгоно.

List Length: Сайтын админий хэсэгт гарч ирэх ямар нэг жагсаалтын уртыг энд зааж өгнө. Ухаандаа та сайт дээр суулгагдсан байгаа модулиудын жагсаалтуудыг харж байлаа гэе. Хэрвээ энд 30 гэж зааж өгсөн байгаад, таны сайтад 80 модуль суулгагдсан байвал 30, 30-аар нь тасал хуудас болгоод 3 хуудас болгож харуулна гэсэн үг шүү дээ.

Favourites Site Icon: Энд таны зааж өгсөн .ico файл дээрх зураг зарим (internet explorer, mozilla firefox) браузер дээр хаягийн талбарт таны сайтны хаягийн зүүн талд гарч ирнэ. Цаанаасаа энд ТАУС-гийн цэцэгний хэлбэртэй логоний зураг заагдсан байгаа. Өөрийн гэсэн зургаа оруулъя гэвэл энэ тохиргоог ашиглаарай.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.2 “Locale” тохиргооны бүлэг:



The screenshot shows the Joomla! Global Configuration interface, specifically the 'Locale' tab. The page title is 'Global Configuration' and it indicates 'configuration.php is : Writeable'. There is a checkbox for 'Make unwriteable after saving'. The 'Locale' tab is selected, and the following settings are visible:


Language:	mongol
Time Offset:	(UTC 00:00) Western Europe Time, London, Lisbon, Casablanca
Server Offset:	0
Country Locale:	en_GB

Language: Сайтдаа ашиглах стандарт хэлийг эндээс сонгоно. Хэрвээ энэ нь Англиас өөр хэл бол тэр нь админий хэсэг дэх “installer” цэсээс суулгагдсан байх ёстой. Таны ТАУС-гийн хувилбартай хамт Англи, Монгол хоёр хэл суулгагдсан байгаа. Өөр хэлүүдийг интернэтээс татаж авах боломжтой.
www.joomla.org

Time Offset: Гринвичийн дундач, таны серверийн байгаа газрын цагийн бүс хоёрын хоорондын зөрөөг эндээс зааж өгнө. Хэрвээ сервер тань УБ-т байдаг бол энэ нь +8 шүү дээ. Манай УБ хот маань гринвичийн 8-р цагийн бүст оршидгийг бид мэднэ.

Country Locale: Энд сайтынхаа байгаа орны нэрийг оруулж өгөх ёстой. Жишээлбэл en_GB гэдэг нь их британийн тохируулга болох юм. Монголынх “mn”









9.3 “Content” тохиргооны бүлэг:



Global Configuration configuration.php is : **Writeable** Make unwriteable after saving

Site Locale **Content!** Database Server Metadata Mail Cache Statistics SEO

* These Parameters control Output elements*

Linked Titles:	<input checked="" type="radio"/> Үгүй <input type="radio"/> Тийм 
Read More Link:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
Item Rating/Voting:	<input checked="" type="radio"/> Hide <input type="radio"/> Show 
Author Names:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
Created Date and Time:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
Modified Date and Time:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
Hits:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
PDF Icon:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Print Icon:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Email Icon:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Icons:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show 
Table of Contents on multi-page items:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Back Button:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show
Content Item Navigation:	<input type="radio"/> Hide <input checked="" type="radio"/> Show

Linked Titles: Энд “тийм” гэдгийг сонговол сайтан дээр гарч ирэх мэдээний товчуудын гарчигийг мэдээний бүрэн эх рvv хетэлдэг холбоостойгоор гаргана. Харин “үгvй” гэвэл мэдээний товчын доод талд “цааш нь унших” нэмэлт холбоосыг оронд нь гаргах юм.

Read More Link: Мэдээний товчын доод талд “цааш нь унших” нэмэлт холбоосыг гаргахыг хvсвэл “show” гэдгийг сонгоно. “hide” гэдгийг сонговол гарч ирэхгvй.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

Item Rating / Voting: Энд хэрвээ “show” гэж сонговол “Блог” хэсэгт ороогүй (бид “Блог” хэлбэрийн мэдээний талаар дээр үзсэн) бөгөөд мэдээний товч-той мэдээнүүд дээр чансааг нь үнэлэх жижиг однууд гарч ирнэ. Үүнийг ашиглан уншигчид мэдээний чансааг од өгч үнэлэх боломжтой болох юм.

Author Names: Мэдээний зохиогчийн нэрийг мэдээтэй хамт гаргахыг хүсвэл энд “show” гэж сонгоно.

Created Date and Time: Мэдээний оруулагдсан огноог мэдээтэй хамт гаргахыг хүсвэл энд “show” гэж сонгоно.

Modified Date and Time: Мэдээний хамгийн сүүлд өөрчлөгдсөн огноог мэдээтэй хамт гаргахыг хүсвэл энд “show” гэж сонгоно.

Hits: Тухайн мэдээг хэдэн хvн орж үзсэнийг мэдээтэй хамт гаргаж харуулахыг хүсвэл “show” гэж сонгоно.

PDF Icon: Мэдээн дээр PDF файл болгон өөрчлөх товчыг нэмж харуулахыг хүсвэл энд “show” гэж сонгоно

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

Print Icon: Мэдээн дээр хэвлэхэд тохиромжтой хувилбарыг гаргах товчыг нэмж харуулахыг хэсвэл энд “show” гэж сонгоно

Email Icon: Мэдээн дээр PDF “энэ хуудсыг найздаа явуулах” товчыг нэмж харуулахыг хэсвэл энд “show” гэж сонгоно

Icons: Дээрх 3 товчыг текстэн холбоосоор биш, зургаар харуулахыг хэсвэл энд “show” гэж сонгоно

Table of Contents on multi-page items: Нэгээс олон хуудастай мэдээ оруулахдаа хуудаснуудын хооронд зорчих боломж олгогч холбоосуудыг гаргаж харуулахыг хэсвэл энд “show” гэж сонгоно. Анх мэдээгээ оруулахдаа шинэ хуудас эхлүүлэхийн тулд {mospagebreak} командыг ашиглана.


Back Button: Вебсайтынхаа хуудас бүрт өмнө нь үзсэн хуудсандаа буцаж зочлох боломж олгодог “буцах” товчыг нэмж өгөхийг хэсвэл энд “show” гэж сонгоно

Content Item Navigation: Олон хуудастай мэдээний доор, эсвэл олон мэдээтэй мэдээний категори нэгээс их хуудастай болчихсон байвал доор нь урагшаа хойшоо явах боломж олгох товчнуудыг гаргахын тулд энд “show” гэж сонгоно


Multi Lingual content support: “Mambelfish” компонентийг сайт дээр ажиллуулахын тулд энд “show” гэж сонгоно. Өмнө нь уг компонентыг суулгасан байх шаардлагатай.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.4 “Database” тохиргооны бүлэг:



Global Configuration configuration.php is :

Site	Locale	Content	Database	Server	Metadata	Mail	Cache	Statistics
Hostname:		<input type="text"/>						
MySQL Username:		<input type="text"/>						
MySQL Password:		<input type="text"/>						
MySQL Database:		<input type="text"/>						
MySQL Database Prefix:		<input type="text"/> 						

Анхааруулга: энэхүү тохиргооны бүлэг дэх зүйлсийг өөрчлөх нь сайтын тогтвортой үйл ажиллагаатай шууд хамааралтай учир та өөрөө ТАУС-г суулгаагүй, эсвэл эдгээрийн үр дагаварыг сайн мэдэхгүй бол байсан чигээр нь орхих нь зүйтэй.

Hostname: Өгөгдлийн баазынхаа хост нэрийг оруулна. Ихэнх тохиолдолд энэ нь “localhost” байдаг.

My SQL Username: Хэрвээ өмнөхөөсөө өөрчлөгдсөн бол өгөгдлийн баазынхаа шинэ хэрэглэгчийн нэрийг оруул

My SQL Password: Хэрвээ өмнөхөөсөө өөрчлөгдсөн бол өгөгдлийн баазынхаа шинэ нууц үгийг оруул

My SQL Database: Хэрвээ өмнөхөөсөө өөрчлөгдсөн бол өгөгдлийн баазынхаа ТАУС-д оноож өгсөн шинэ баазын нэрийг оруул

My SQL Database Prefix: Хэрвээ өмнөхөөсөө өөрчлөгдсөн бол өгөгдлийн баазынхаа ТАУС-д оноож өгсөн шинэ префиксийг оруул. Уг нь mos_ гэж байх ёстой.

Анхааруулга: Мэдээллийн бааз дотроо тохирсон префикс бүхий шинэ бааз үүсгээгүй цагтаа энд шинэ бааз зааж өгвөл таны сайт ажиллахаа болино шүү.

9.5 “Server” тохиргооны бүлэг:

The screenshot displays the 'Server' configuration tab with the following settings:

- Absolute Path: [Redacted]
- Live Site: [Redacted]
- Secret Word: zYudMFhXdqIYUMwV
- GZIP Page Compression: Үгүй Тийм
- Login Session Lifetime: 900 seconds
- Error Reporting: System Default
- Help Server: [Redacted]
- File Creation: **File Permissions**
 - Dont CHMOD new files (use server defaults)
 - CHMOD new files
- Directory Creation: **Directory Permissions**
 - Dont CHMOD new directories (use server defaults)
 - CHMOD new directories

Эдгээр тохиргоонууд нь ТАУС-г суулгахтай хамт утгаа авчихсан бөгөөд энэ бүлгээс утгыг нь өөрчлөх боломжгүй:

Absolute Path: Энэ нь сайтын байрлаж буй сервер дээрх ТАУС-гийн вебийн бусад вебүүдтэй харьцангуй, абсолют зам нь болно

Live Site: Сайтын Вебийн хаяг буюу абсолют URL хаяг.

Secret Word: Хамгаалалтын зорилгоор ТАУСгийн бие даасан суулгац болгонд оноогддог нууц үг.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

GZIP Page Compression: - Хэрвээ хэрэглэгчийн браузер нь тухайн функцийг дэмждэг бол серверээс илгээх мэдээлээ GZIP технологиор шахаж явуулахыг зөвшөөрөхийн тулд “Тийм” гэдгийг сонгоно. Энэ нь уг хэрэглэгчдийн хувьд таны вебийг татаж үзэх цагийг ихээхэн хурдасгах ач холбогдолтой юм.

Login Session Lifetime: - Администратор сайтад нэвтрэсний дараа хэдэн секунд идэвхгүй байвал автоматаар сайтаас гаргахыг эндээс зааж өгнө. Ингэж гарсны дараа админ нэр, нууц үгээ дахин хийж байж орох шаардлагатай болно.

Сануулга: мэдээ засварлаж байх үедээ та энд заасан хугацааны дотор хадгалаагүй бол сайтад нэвтэрсэн мэдээлэл тань ийнхүү автоматаар хвчингүй болох болно гэдгийг санаарай.

Error Reporting: - “Site” тохиргооны бүлэг дээр энэхүү функцийг идэвхжүүлсэн бол эндээс алдааны тайланг ямар түвшинд гаргахыг зааж өгнө. Үүнд System Default, None, Simple болон Maximum гэсэн 4 түвшин байна:

System Default - Энэ нь сервер дээрх **php.ini** файл дээр заасны дагуу системийн тохиргоог тохируулна.

None - Энэ нь алдааны тайлангийн функцийн ажиллагааг зогсооно.

Simple - Энэ нь доорх тохиргоог ашиглан алдааны тайланг энгийнээр гаргаж ирнэ: `error_reporting (E_ERROR|E_WARNING|E_PARSE)`

Maximum - Энэ нь доорх тохиргоог ашиглан алдааны тайланг энгийнээр гаргаж ирнэ: `error_reporting (E_ALL)`


Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

File Creation: Компонент, модуль, мамботуудыг суулгахтай хамт үүсгэгдсэн файлууд цаанаасаа серверийн стандарт хандалтын зэргийг автоматаар авахаар тохируулагдсан байгаа. Эндээс "CHMOD new files" гэснийг сонговол ийнхүү шинээр үүсгэгдсэн файлуудын хандалтын зэргийг тус бүрд нь оноож өгөх боломжтой болох юм.

Directory Creation: Дээрх файлуудтай мөн адил фолдерууд шинэ нэмэлт программ суулгахтай хамт үүсгэгддэг бөгөөд мөн цаанаасаа серверийн стандарт хандалтын зэргийг автоматаар авахаар тохируулагдсан байгаа. Эндээс "CHMOD new directories" гэснийг сонговол ийнхүү шинээр үүсгэгдсэн фолдеруудын хандалтын зэргийг тус бүрд нь оноож өгөх боломжтой болох юм.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.6 “Metadata” Тохиргооны бүлэг:



The screenshot shows the Joomla! Global Configuration interface, specifically the Metadata tab. The page title is "Global Configuration" and it indicates "configuration.php is : Writeable". There is a checkbox for "Make unwriteable after saving". The tabs include Site, Locale, Content, Database, Server, Metadata (selected), Mail, Cache, Statistics, and SEO. The Metadata section contains the following fields:

- Global Site Meta Description: Joomla - the dynamic portal engine and content management system
- Global Site Meta Keywords: Joomla, joomla
- Show Title Meta Tag: Үгүй Тийм
- Show Author Meta Tag: Үгүй Тийм

Global Site Meta Description: Интернэтийн хайлтын системүүдэд зориулсан сайтныхаа танилцуулгыг бичиж оруулна уу. Та энэхүү танилцуулгаа өөрийн зорилтот хайлтын системээсээ шалтгаалаад дунджаар 20 үгэнд багтаавал зохино. Энд та өөрийн сайтын агуулгыг нэг үгээр илэрхийлсэн “түлхүүр үг”-нүүдээ оруулах хэрэгтэй. Зарим хайлтын систем 20-иос олон үг зөвшөөрдөг тул нэмэлт нэг хоёр өгүүлбэр бичиж болно. Хамгийн чухал хэсгээ гэвч эхний 20 үгэнд багтаагаарай.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

Global Site Meta Keywords: Энд та өөрийн сайтын агуулгыг нэг үгээр илэрхийлсэн “түлхвэр үг”-нүүдээ оруулах хэрэгтэй. Эдгээр үгнүүд нийтдээ 300-500 тэмдэгтээс бүтсэн байх ёстой ба үгнүүдээ хооронд нь зай авах буюу таслал тавьж салгаж болно.


Show Author Meta Tag: Хэрэглэгчид таны сайтын “source code” буюу HTML кодыг браузерасаа үзэх үед сайтыг хийсэн хүний мета мэдээлэл гарч ирэх эсэхийг энд зааж өгнө.



:: Мета мэдээлэл

Дээр таны оруулсан сайтын танилцуулга болоод түлхвэр үгнүүд (мета мэдээлэл) нь хайлтын системүүд таны сайтыг хэрхэн тодорхойлж өөрсдийн жагсаалтанд оруулахыг заана. Зарим хайлтын системүүд мета мэдээллийг хэрэгсдэггүй. Тиймээс хэрвээ танд хайлтын системүүдээс орж ирдэг хэрэглэгчийн урсгал хэрэгтэй бол “хайлтын системийн оптимизаци” (SEO - Search Engine Optimization)-ын талаар бие даан судлах нь зүйтэй болох болов уу.

9.7 “Mail” Тохиргооны бүлэг:



The screenshot shows the Joomla! Global Configuration interface, specifically the 'Mail' tab. The configuration is for 'configuration.php' which is 'Writeable'. A checkbox for 'Make unwriteable after saving' is present and unchecked. The 'Mail' tab is selected among other tabs like Site, Locale, Content, Database, Server, Metadata, Cache, Statistics, and SEO. The configuration fields are as follows:

Mailer:	PHP mail function
Mail From:	sdf@sdf.com
From Name:	Den of Joomla
Sendmail Path:	/usr/sbin/sendmail
SMTP Auth:	<input checked="" type="radio"/> Үгүй <input type="radio"/> Тийм
SMTP User:	
SMTP Pass:	
SMTP Host:	localhost

Mailer: Ямар терлийн мэйлийн систем ашиглахаа зааж өгнө: **PHP mail function, Sendmail or SMTP Server.**

Mail From: Мэйлийг илгээж буй хвний хаягны талбар дээр гарч ирэх хаягийг энд бичиж өгнө. Хүлээн авагч энэ хаяг руу хариугаа явуулах юм.

From Name: Мэйлийг илгээж буй хвний нэрний талбар дээр гарч ирэх нэрийг энд бичиж өгнө.

Sendmail Path: Мэйл серверийн байршиж буй фолдерийг зааж өгнө.

SMTP Auth: Таны сервер SMTP хандалтыг хянан тохируулах (SMTP Authentication) шаардлагатай бол энд “Тийм” гэж сонгоно.

SMTP User: Хэрвээ хандалтыг хянах шаардалгатай бөгөөд дээр тэгнэ гэж зааж өгсөн бол энд SMTP хэрэглэгчийн нэрийг оруулна уу.

SMTP Pass: Хэрвээ хандалтыг хянах шаардалгатай бөгөөд дээр тэгнэ гэж зааж өгсөн бол энд SMTP нууц үгийг оруулна уу.

SMTP Host: SMTP серверийн нэр. Энэ нь ихэнхдээ localhost гэж байдаг боловч хэрвээ үүнээс өөр бол энд оруулж өгнө.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.8 “Cache” Тохиргооны бүлэг:



The screenshot shows the Joomla! Global Configuration interface. At the top, it says "Global Configuration" and "configuration.php is : Writeable". There is a checkbox for "Make unwriteable after saving". Below this are several tabs: Site, Locale, Content, Database, Server, Metadata, Mail, Cache (selected), Statistics, and SEO. The "Cache" tab is active, showing the following settings:

- Caching: Үгүй Тийм
- Cache Folder: 
- Cache Time: seconds

Caching: Энд “Тийм” гэж сонгон ТАУС доторх тодорхой зарим элементийг кэшлэх зөвшөөрлийг олгоно. Ингэснээр ерөнхийдөө таны сайтыг хэрэглэгч үзэх хурд сайжрах юм.

Cache Folder: Дээр “Тийм” гэж сонгосон бол эндээс та кэш файлуудаа хадгалах фолдерийг оноож өгөх хэрэгтэй. Энэ фолдер нь бичих эрхтэй байх ёстой бөгөөд энэ талаар мэдэхгүй зүйл байвал веб мастераасаа асуугаарай.

Cache Time: Кэш файл шинэчлэгдэхээсээ өмнө хэвээрээ хадгалагдах хугацааг секундээр оруулж өгнө үү.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.9 “Statistics” Тохиргооны бүлэг:



Statistics: Хэрвээ энд “Тийм” гэж сонговол Content тохиргооны бүлэг дээр заасны дагуу хэрэглэгчийн домэйн, браузерын мэдээллийг цуглуулах юм. Харин “Үгүй” гэж сонговол хэрэглэгч, браузерын статистик мэдээлэлийг сервер цуглуулахаа зогсооно. Хэрвээ хэрэглэгч анх удаа танай сайтыг үзэх вед бага зэрэг удаан уншиж байгаа нь ажиглагдвал энэ тохиргоог “Үгүй” болгосноор янзлах боломжтой.

Log Content Hits by Date: Энд “Тийм” гэж сонгосноор мэдээнүүдийн уншигдсан тоог өдөр бүрээр хадгалах боломжтой. Энэ статистик мэдээлэл дээр анализ хийх ТАУС-тай хамт суусан программ байхгүй учраас уг мэдээллийг тэр хэвээр нь ашиглах болно.

Анхааруулга: Энэхүү тохируулгыг ажиллуулсны үр дүнд цаг хугацааны турш танай сервер дээр өдөр бүрийн мэдээний уншигдсан тоог агуулсан ихээхэн хэмжээний мэдээлэл, олон файл үүсэх учир таны сервер эдгээрийг хадгалах хангалттай зайтай эсэхийг бодолцож үзээрэй.

Log Search Strings: Хэрэглэгчид танай сайтын хайлтын системийг ашиглан сайтан дээрээс юм хайсан түлхүүр үгнүүдийн мэдээллийг хадгалахыг хүсвэл энд “Тийм” гэж сонгох хэрэгтэй. Энэ нь танд сайтаа эдгээр түгээмэл түлхүүр үг дээр түшиглэн сайтынхаа агуулгыг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй нийцүүлэх боломжийг олгох юм. Энэ мэдээлэл дээр тулгуурласан анализыг админий удирдлагын самбарын толгойн цэсээс Site > Statistics > Search замаар орж авах боломжтой.

Есдүгээр хэсэг: Глобал тохиргоо

9.10 “SEO” Тохиргооны бүлэг:




Search Engine Friendly URLs: Энэхүү тохиргоо нь таны сайтан дээрх холбоосуудыг шинэчлэн, хайлтын системийн ботууд таны сайтын бие даасан хуудсуудад хандах боломжийг ихэсгэх юм. Энэ нь зөвхөн Apache сервертэй сайтуудад л хийгдэх боломжтой гэдгийг анхаарна уу. Эндээс “Тийм” гэж сонговол ТАУС энгийн өгөгдлийн баазын холбоосуудын оронд хайлтын системд тохиромжтой тусгай холбоосуудыг үүсгэх болно. Хэрвээ энэ тохиргоог хэрэглэх болвол та htaccess.txt файлынхаа нэрийг .htaccess. болгож өөрчлөх шаардлагатай.

Dynamic Page Titles: Сайт доторх бие даасан хуудсуудын гарчиг нь хэрэглэгчийн браузерын толгой дээр гардаг хуудсын гарчигтай адил болгохын тулд энд “Тийм” гэж сонгоно. Энэ нь мөн л хайлтын систем таны хуудсуудыг илүү өндөр нарийвчлалтай гаргаж ирэхэд нөлөөлнө.

Ийнхүү тохиргоонуудаа хийгээд дууссаныхаа дараа та үйлдсэн өөрчлөлтүүдээ

хадгалахын тулд  **SAVE** товчыг дарахаа мартаузай.


Хэрвээ сая оруулсан өөрчлөлтөө хадгалахыг хүсэхгүй бол  **CLOSE** товчыг дарна. Браузерынхаа “Буцах” товчыг биш энэ товчыг ашиглах хэрэгтэй шүү. Хэрвээ тэгэхгүй бол өөр админ таны дөнгөж сая үзэж байсан хэсэгт өөрчлөлт хийх боломжгүй түгжигдчихдэг юм.

Аравдугаар хэсэг: Вебсайт харах, Сайтын статистик

10.1 Вебсайт харах

Site Preview

ТАУС-ын толгойн цэсээс орох зам: **Site > Preview**



ТАУС-ын удирдлагын самбараас вебсайтын агуулга, дизайныг өөрчилж байх явцдаа хийсэн өөрчлөлтүүд нь сайт дээр хэрхэн орж байгааг түргэн харахад зориулан “вебсайт харах” тохиргоог толгойн цэсэн дээр оруулсан байгаа. Дээрх замын дагуу орсноор танд энэхүү 3 төрлөөр вебээ харах боломж бий болох юм:

- **In New Window**
- **Inline**
- **Inline with Positions**

Эдгээрийн алийг нь ч сонгосон таны вебийн нүүр хуудас дэлгэцэн дээр гарч ирэх болно. Тухайлбал **In New Window** гэсэн хамгийн эхний сонголт нь сайтын нүүр хуудсыг агуулсан шинэ браузерын цонх нээх юм.

Аравдугаар хэсэг: Вебсайт харах, Сайтын статистик

Харин **Inline** сонголтыг сонгосноор веб сайтынхаа нүүр хуудсыг одоо ажиллаж байгаа цонхон дээрээ шинэ фрэйм (Frame) үүсгэн харах боломжтой.


Гурав дахь сонголт буюу Inline with **Positions** нь таны одоогоор сонгосон байгаа вебийн загвар дээр тусгагдсан блокуудын ("**User3**," "**Right**," "**Left**," "**Debug**" гэх мэт бид дээр үзсэн) байршлыг харуулах болно. Энэхүү байршлууд дээрх мэдээ, мэдээлэл, хобоос, цэсүүд хэрхэн орсныг эндээс харж, хянах боломжтой юм. Эдгээр блокуудын аль нь дээр нь ч аль ч агуулгыг оруулах боломжтой байдгийг бид дээр үзсэн билээ. Аливаа агуулгын тохиргооны **details** хэсэгт энэхүү байршлын тохируулга байдаг.

Аравдугаар хэсэг: Вебсайт харах, Сайтын статистик

10.2 Сайтын статистик

Statistics

ТАУС-ын толгойн цэсээс орох зам: **Site > Statistics**



Таны сайт руу зочилж буй хэрэглэгчдийн браузер, домэйн, вйлдлийн систем гэх мэтийн талаарх статистик мэдээллийг ТАУС цуглуулан танд хэрэглэгчдийнхээ талаар тодорхой ойлголттой болоход туслана.

Үүнд 3 төрлийн статистикийн мэдээлэл байна:

- **Browser, OS, Domain**
- **Page Impressions**
- **Search Text**

Тэмдэглэл: Эдгээр статистикийн хэрэгслүүдийн ихэнх нь цаанаасаа идэвхжүүлэгдээггүй байдаг учраас Site > Statistics гээд ороход юу ч байхгүй байвал Глобал тохиргооны тохирох бүлгээс идэвхжүүлэх хэрэгтэй.

Browser, OS, Domain Statistics:

Зочидын Браузер, Үйлдлийн систем, Домэйний статистик

Эхний бүлэгт таны сайтад зочлохдоо хэрэглэгчидийн ашигласан браузерын статистик байна. Ерөнхийдөө энд үр дүн нь буурах дарааллаар браузерын нэрээр ангилагдсан байгаа. Эндээс та хэрэглэгчид таны сайтыг үзэхдээ ямар браузерыг хамгийн их ашиглах байгааг харах боломжтой.

Тэмдэглэл: Зарим веб браузерууд сайтад өөрийгөө ямар нэг өөр, өргөн хэрэглэгддэг браузер гэж “хэлэх” чадвартай байдаг учир энэхүү бүлэгт гарч ирсэн үр дүнг 100% үнэн гэж хэлж болохгүй юм. Энэ нь магадгүй зарим веб сайтууд зөвхөн Internet Explorer программаар үзэх боломжтой гэдэг шиг зүйлс хийдэгтэй холбоотой байдаг.

Аравдугаар хэсэг: Вебсайт харах, Сайтын статистик

Баганын гарчигны хажууд байгаа гурвалжин дүрсийг ашиглан буурах дараалалыг есэх дараалал болгон өөрчилж болно. Үүнээс гадна баруун дээд талын % гэсэн баганын гарчигны хажууд байгаа дүрсийг дараад харьцангуй хувиар эрэмбэлж болно. Эргээд браузерийн нэрээр эрэмблэхийн тулд дахиад хуучин гурвалжин дүрсээ дарахад л болно.

2 дахь бүлэгт OS - Operating System буюу бидний нэрлэж занснаар “Үйлдлийн Систем”-ийн хэрэглээний статистик бий. Энэхүү статистикийг та өмнөх браузерийн хэрэглээний мэдээлэлтэй адилаар үйлдлийн системийн нэр, харьцангуй хувиар нь эрэмблэх боломжтой.

Энэ нь хэрэглэгч таны сайтыг ямар үйлдлийн систем ашиглан үзэж байгааг хэлэх болно. Браузерийн статистиктай мөн адил энэ нь 100% үнэн гэж үзэж болохгүй боловч нөгөөдөхөө бодвол илүү үнэн байх магадлалтай..

3 дахь бүлэгт хэрэглэгчийн сайтыг үзэхдээ дамжиж орсон дээд түвшний домэйний (top-level domain) хэрэглээний статистик бий. Энэхүү статистикийг та өмнөх мэдээлэлүүдтэй адилаар нэр, харьцангуй хувиар нь эрэмблэх боломжтой.

Page Impressions:

Энэ нь хамгийн олон үзсэн мэдээ, мэдээллийн статистик мэдээг тайлагнах үүрэгтэй. Хэрэглэгчдийн хамгийн олон зочилсоноор нь веб хуудсуудыг ангилдаг.

Аравдугаар хэсэг: Вебсайт харах, Сайтын статистик**Search Text:**


Хэрэглэгчдийн нүүр хуудас дээрх хайлтын талбарт оруулж хайлт хийсэн твлхүүр үгүүдийн жагсаалтыг оруулсан тоотой нь хамт эндээс харж болно. Багануудад оруулсан твлхүүр үг (# Search text), уг үгийг оруулж хайлт хийсэн тоо (Times Requested), уг үгийг оруулж хайлт хийхэд гарч ирэх үр дүнгийн тоог (Results Returned) харуулж байна.

Энэхүү мэдээллийг мэдсэнээр та сайтаа хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээтэй зохицуулан өөрчилж, магадгүй өмнө нь хэн ч үздэггүй байсан сайтынхаа тодорхой хэсэг, тодорхой мэдээ, мэдээллийн твлхүүр үг сэлтийг өөрчилснээр уг байдлыг зогсоох боломжтой болох юм. Ухаандаа хэрэглэгчид нэг твлхүүр үгийг байнга таны оруулснаас өөрөөр оруулж хайдаг байвал та өөрийнхөө твлхүүр үгийг түүнтэй нь уялдуулан сольсноор өмнө нь гарч ирдэггүй байсан үр дүн дараагийн удаа хэрэглэгчийг уг үгээр хайхад гар ирэх жишээтэй.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд**11.1 Сайтын загвар****Template Manager**

Толгойн цэсээс орох зам: **Site > Template Manager**

Вебийн загвар нь Сайтын (Site Templates) болон Админий (Admin Templates) гэсэн хоёр янз байна. Эхнийх нь сайтын хэрэглэгчдэд зориулсан бол хоёр дахь нь админы удирдлагын самбарт зориулсан загвар байгаа юм. Та Template Manager гэж орсны дараа дээрх хоёрын аль нэгийг сонгох боломжтой байгааг харж болно:



Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Веб сайтын харагдах байдал, зочдод таалагдахад нь сайтын загвар (Site Templates) хамгийн илүү нөлөөтэй болох нь мэдээж. Тиймээс бүгдээрээ сайтын загвараа хэрхэн өөрчлөх талаар цааш нь ярилцъя:



The screenshot shows the Joomla! Template Manager interface. At the top, there are navigation buttons: Default, Assign, Delete, Edit HTML, Edit CSS, New, and Help. Below the buttons, the title "Template Manager [Site]" is displayed. A table lists the available templates:

#	Name	Default	Assigned	Author	Version	Date	Author URL
1	madeyourweb			Marc Hinse	1.3	15 09 2005	http://www.madeyourweb.com
2	rhuk_solarflare_ii	✓		rhuk	2.2	10/20/05	http://www.jamboworks.com

Сайтан дээр суучихсан байгаа загваруудын жагсаалт Template Manager цонхон дээр гарч ирнэ. “Name” баганын доор сайтын загварын нэрсийн жагсаалтыг харж болно. Одоогоор таны сайтын үндсэн загвар байгаа нь нэрнийхээ баруун талд ногоон чагттай байгаа. Хэрвээ эдгээр загваруудын аль нэгийг нь та өөрийн вебсайтынхаа үндсэн загвар болгон солихыг хүсвэл хүссэн загварынхаа нэрийн зүүн талд байгаа нүднээс сонгоод **Default** товчыг дараарай.

Та сайтын загварыг бүх сайтаар нь солихоос гадна бие даасан хуудас бүрт өөр өөр загвар оноож өгч болно. Ингэхийн тулд эхлээд загвараа сонгоод, дараа нь баруун дээд талаас **Assign** товчыг дараад, гарч ирсэн цонхноос аль хуудсан дээр сая сонгосон загвар тань гарахыг сонгох хэрэгтэй.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Ийнхүү хуудсаар нь оноож өгсөн загвар нь сайтын үндсэн загварыг тухайн хуудсан дээр хвчингүй болгон өөрөө автоматаар ордог. Харин дараа нь ийнхүү өөр загвар оноож өгсөн хуудсаа буцаагаад хэвэнд нь оруулахын тулд дахин Template Manager-с уг загвараа сонгоод **Assign** товчин дээр дарах ба гарч ирсэн цонхноос өөрийнхөө урд нь идэвхжүүлсэн хуудсан дээрээ дарж идэвхгүй болгох буюу жагсаалтын дээд хэсэгт байгаа “None” гэсэн сонголтыг идэвхжүүлээд



SAVE товчыг дарна.

Шинээр сайтын загвар суулгах, өмнө суусан загварыг устгах

Юуны өмнө та шинээр сайтын загварын файлууд ч бай, шинэ модуль, компонент, ямар нэг нэмэлт программ сайтдаа суулгахын тулд эхний ээлжинд өөрийн компьютерийн хатуу дискэн дээр тухайн программаа байлгаж байх ёстой. Эдгээрийг олж авах хамгийн тохиромжтой эх сурвалж нь, мэдээжээр, интернэт билээ.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Үүний тулд та энгийн хайлтын систем дээр “Joomla templates”, “Joomla modules, components” (ТАУС системийн маань “эх” системийн нэр, энэхүү системд зориулж хийсэн ямар ч программ ТАУС дээр ажиллана) гэх мэтээр хайн мянга мянган веб сайтыг олж болохоос гадна энд танд амарыг бодоод хэд хэдэн бэлэн холбоосыг тавичихъя:

<http://www.joomlatribune.com/>

<http://www.joomlaresource.com/>

<http://www.joomlashack.com/>


Эдгээр вебүүд мэдээж бүгд Англи хэл дээр байгаа. Сайтдаа шинэ загварын файлууд татаж авахын тулд эдгээр сайтуудаас “Template” гэсэн хэсгийг нь хайж олоорой.

За ингээд ямар ч байсан та загварынхаа файлуудыг өөрийн компьютер дээр хуулчихсан бол үүнийг сайт руугаа хуулж, суулгах 2 арга байна. Хэрвээ та анзаарсан бол загварын файлууд .zip, .gzip гэх мэт форматаар шахагдсан байгаа. Эдгээр нь таны суулгах хөдөлмөрийг хөнгөвчлөхийн тулд хийгдсэн юм. Гэвч ийм шахсан файлыг шууд суулгахын тулд таны сервер дээрх PHP тань “gzip support” буюу zip форматаар шахагдсан файльтай шууд ажиллах боломжтой байх хэрэгтэй. Энэ талаар та өөрийн сервер дээрх администратороос асуугаарай. Юуны өмнө бид сайтын загвар суулгах удирдлагын цонх руу орох хэрэгтэй.

Installers > Templates - Site (Админы интерфэйсын загвар суулгаж байгаа тохиолдолд **“Templates - Admin”**) гэж орох хэрэгтэй.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Install New Template цонх:



The screenshot shows the Joomla! Template Manager interface for installing a new template. It features two main sections: 'Upload Package File' and 'Install from directory'. The 'Upload Package File' section includes a text input for 'Package File', a 'Browse...' button, and an 'Upload File & Install' button. The 'Install from directory' section shows a path input field with the value 'C:\apache2triad\htdocs\joomla\administrator\components\com_installer' and an 'Install' button. Below this, a list of directories is shown with their permissions: 'media/' (Writeable), 'administrator/templates/' (Writeable), 'templates/' (Writeable), and 'images/stories/' (Writeable). A 'Back to Templates' link is located in the top right corner.


Хэрвээ таны сервер дээрх PHP дээр өгүүлсэн gzip support гээчийг дэмждэг бол **“Upload Package File”** хэсгээс **“Browse”** товчыг даран гарч ирсэн цонхноос өөрийн .zip өртгөтгөлтэй загварын файлаа зааж өгөөд, **“Upload File & Install”** товчыг дарна. Үүний дараа таны сайт дээр саяны сайтын загвар автоматаар суулгагдах юм.

Харин дээрх gzip support таны сервер дээр байхгүй бол та өөрийн загварын файлаа эхлээд өөрийн хатуу дискэн дээрээ задлаад, дараа нь тэр бүх файлуудаа сервер рүүгээ нэг фолдер дотор хуулж өгөх шаардлагатай. Үүнийхээ дараа сервер дээрх уг загварын файльтай фолдерынхоо замыг **“Install from directory”** талбарт бичиж оруулаад **“Install”** товчыг дарна. Шинэхэн серверүүд ихэнхдээ gzip support-той байдаг.

Загвараа суулгасныхаа дараа дээр бидний ярилцсан Template Manager руу орж сонгосноор сайт тань уг шинэ загварын дагуу өөрчлөгдөх болно.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Module Positions цонх



Den of Joomla! / com_templates / positions

Module Positions

#	Position	Description	#	Position	Description
(1)	left		(2)	right	
(3)	top		(4)	bottom	
(5)	inset		(6)	banner	
(7)	header		(8)	footer	
(9)	newflash		(10)	legals	
(11)	pathway		(12)	toolbar	
(13)	cpanel		(14)	user1	

Толгойн цэсээс Site > Template Manager гээд орохоор дээр бидний ярилцсан хоёр янзын загварыг удирдах цонх руу орох 2 холбоосноос гадна “Module Positions” гэсэн гурав дахь холбоос байсныг анзаарсан байх аа. Энэ нь бидний байн байн үзсэн веб хуудсан дээр цаанаас нь оноож өгсөн тодорхой байршлуудын нэрийг солих боломж олгодог юм.

Та эндээс модулийн байршлуудын нэрийг илүү ойлгомжтой, санахад хялбар болгон өөрчлөх, хуудасны яг хаана байдгийг нь сануулсан жижиг тайлбар нэмж өгөх боломжтой. Оруулах үгээ тохирох талбарт нь бичиж өгөөд **SAVE** товчыг дараарай.


Ерөнхийдөө эдгээрийн нэрийг өөрчлөх, шинэ байршил нэмэх шаардлага танд бараг гарахгүй болов уу. Учир нь эдгээр нь тодорхой нэг хуудсыг бүхэлд нь хуваагаад 22 байршил болгочихсон байгаа тул тэрхүү хуудсанд оруулах гэсэн бүх мэдээлэл онолын хувьд энэ байршлуудад багтах ёстой. Шинэ байршил нэмвүлье гэвэл сервер дээрх админуудтай холбоо барьж хүсэлт гаргаарай.

Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

11.2 Устгагдсан агуулгууд


Trash Manager

Толгойн цэсээс орох зам: **Site > Trash Manager**




Trash Manager буюу хогийн сав нь ихэнх вйлдлийн системүүдэд байдаг шиг устгагдсан мэдээллийг хадгалдаг тусгай хэсэг юм. Үүний тусламжтай та мэдэлгүй устгачихсэн зүйлсээ буцаан сэргээж болно:

Trash Manager цонх



Арван нэгдүгээр хэсэг: Сайтын загвар, Устгагдсан агуулгууд

Та мэдээ, категори, секц, эсвэл цэсийн элемент буюу холбоосыг хэрэгслийн мөрнөөс **“Trash”** товчыг даран **Trash Manager** руу илгээнэ. Харин ийнхүү хогийн

саванд орж ирсэн мэдээ тэргүүтнийг та  **Restore** буюу буцаан сэргээх,

эсвэл  **Delete** буюу бүрмөсөн устгах гэсэн хоёр сонголттой.

Хогийн сав нь **“Content Items”** буюу мэдээ, мэдээлэл, категори, секцүүдийг агуулсан нэг, **“Menu Items”** буюу холбоосуудыг агуулсан нэг, нийтдээ хоёр бүлэгтэй байгааг дээр тойруулан зурж тэмдэглэсэн байна.

Энэ хоёрын аль нэгээс нь өөрийн буцаан сэргээх, эсвэл бүрмөсөн устгахыг хүссэн элементээ нэрнийх нь урд байгаа дөрвөлжин дээр тэмдэглээд устгах бол **Delete** дээр, сэргээх бол **Restore** дээр дарахад л болно.

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

Бид ТАУС систем, ер нь агуулга удирдах системтэй шинээр танилцаж байгаа хүн бүрт зориулаад хэдэн хялбар зөвлөгөө бичихээр шийдлээ. АУС бол өнөөдөр интернэт дээр нарийн төвөгтэй, олон хуудас мэдээлэл, динамик агуулгатай веб сайтыг веб программчлалын тодорхой мэдлэггүй хүн ч хөтлөн явуулах боломж олгодоггоороо бидний хэн хэний маань амьдралыг хөнгөвчилж байгаа билээ.

Тийм ч учраас өнөө олон хүн ижил төстэй агуулга удирдах системийг ашигладаг юм. Гэхдээ хэрвээ та өмнө нь энэ төрлийн программыг ашиглаж байгаа бол зарим энгийн зүйлсийг илүү төвөгтэй болгочихсон юм шиг санагдаж магадгүй.

Бид өөрсдөө ТАУС-ыг суулгахаасаа өмнө агуулга удирдах системүүдийн талаар огт сонсоогүй байсан болохоор хэрвээ та бидэнтэй адилхан нөхцөлд байгаа бол доорх хэдэн зөвлөгөө танд тус болох байхаа гэж найдаж байна. Өмнө нь энэхүү гарын авлагатаа тайлбарласан, та өөрөө удирдлагын самбар дахь хэрэгслүүдийг оролдож байгаад ойлгочихож болох зүйлсээс энд аль болох зайлсхийсэн байгаа.

Энэхүү зөвлөгөө маань доорх 4 хэсгээс бүрдэнэ:

1. Агуулга удирдах систем гэж юу вэ?
2. Вебсайтаа хэрхэн зохион байгуулах вэ?
3. Сайтынхаа дизайныг тохируулах
4. Модуль, компонент, мамбот

Нэмэлт: Хэрвээ та мэдээ, санал асуулга, блогуудтай сайт хийхийг хүсч байгаа бол ТАУС маш сайн тохирно. Гэхдээ ажиллаж сурахын тулд бага зэрэг цаг зарцуулах хэрэгтэй шүү.

Дараагийн зөвлөгөө: Агуулга удирдах систем гэж юу вэ?

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө**Агуулга удирдах систем гэж юу вэ?**

Интернэт ашигладаг ихэнх хүмүүс веб сайтыг хоорондоо холбоосуудаар дамжин холбогдсон хуудаснууд гэж ойлгодог. Эдгээр хуудсууд нь нэг оруулчихсан бол дахиж өөрчлөгдөггүй статик мэдээлэлтэй байдаг (вебийг хийсэн хүн нь өөрчлөх хүртэл). Энэ нь веб сайтуудад мод хэлбэрийн бүтэц өгдөг юм. Нүүр хуудас нь 6 дэд хуудас руу хандсан холбоостой, дэд хуудас нь тус бүрдээ өөр өөр нийтлэлтэй 10 хуудас руу хандсан холбоостой гэх мэт.

Харин ТАУС нь энэхүү уламжлалт бүтцээс өөрөөр зохион байгуулагддаг. Учир нь ТАУС-ыг ашиглан хийсэн веб сайтын агуулгын ихэнх нь динамик - зочдын оруулсан санал сэтгэгдэл, шууд өөр сайтнаас татаж авсан мэдээ, мэдээлэл, гишүүдийн оруулсан мэдээ г.м. - байдаг юм. Динамик агуулгатай хуудас зочин уг хуудсыг дуудаж үзэх бүрт өөрийн агуулгаа шинэчилж байдгаараа онцлогтой. Тиймээс бидний уламжлалт ойлголт шиг дээрээ тодорхой, хөдлөшгүй мэдээлэлтэй хуудас ТАУС дотор байхгүй гэдгийг ойлговол зохино (ТАУС-ын веб хуудаснуудын талаар 4-р зөвлөгөөнөөс дэлгэрэнгүй үз)

Таны сайтын хуудас бүхэн агуулгын блокуудтай (эдгээр блокуудыг “байршил” гэж нэрлэдэг талаар бид гарын авлага дээр үзсэн) байна. Хуудасныхаа блокуудыг аль нь хаана байрлахыг бид Template буюу сайтын загварыг ашиглана тодорхойлно. Загвар нь блокуудын хуудсан дээрх байршлаас гадна текстийн өнгө, фонт, арын өнгө тэргүүтнийг заадаг юм. Ингээд эцэст нь хуудас дээр та мэдээ, мэдээллээ оруулаад, хуудасныхаа үндсэн хэсэгт харгалзуулж өгнө. (үнэндээ та мэдээллээ цэсийн элемент буюу холбоосонд харгалзуулж байгаа боловч тэднийг төвөгтэй болгохгүйн үүднээс бие даасан хуудас гээд ойлгочихъё)


За бид ерөнхийдөө агуулга удирдах системийн талаар иймэрхүү ойлголттой болсноо хангалттай гэж үзээд дараагийн зөвлөгөөндөө орцгооё.

Дараагийн зөвлөгөө: [Вебсайтаа хэрхэн зохион байгуулах вэ?](#)

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө**Вебсайтаа хэрхэн зохион байгуулах вэ?**

Та өөрийн вебээ аль болох хурдан ажилд оруулахыг хвсч байгаа нь мэдээж боловч үүнийхээ өмнө ТАУС-ыг аль болох сайн эзэмших хэрэгтэй шүү дээ. Анхныхаа хуудсыг хийхээсээ өмнө таны мэдвэл зохих цэснэгвй зүйл бий. Гэвч санаа зоволтгвй ээ - сайтныхаа үндсэн зарчмыг сайтар хичнээн том, төвөгтэй сайт хийх ч хялбархан болох болно.

ТАУС-ын одоогийн хувилбар нь мэдээллийн шатлалын статик зарчмыг баримтладаг. Та мэдээ, мэдээллүүдээ илүү ч биш, дутуу ч биш гурван түвшинд хуваах хэрэгтэй. Дараагийн хувилбараас үүнийг динамик зарчимд шилжүүлэх болов уу. Тэр үед хэрвээ та нэг түвшинтэй баймаар байвал нэг, 10-тай баймаар байвал 10-ыг зааж өгөх боломжтой болох болно. Гэхдээ одоохондоо, та дээрх гурван түвшинг л хэрэглэх шаардлагатай: Секц, Категори, Мэдээ



Секц гэдэг нь хамгийн том сав нь. Энэ саван дотор категори гэдэг арай жижиг савнууд оршино. Харин категори нь дотроо мэдээнүүдийг байлгадаг юм. Хамгийн гол зүйл нь та мэдээндээ дотор нь орж байрлах категори, секц үүсгэлгвй шууд дан мэдээ үүсгэж болохгвй гэсэн үг.

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

Нарийн бичгийн даргийн ширээг сана л даа. Секцүүд нь ширээний шургуулганууд гэсэн үг. Категориуд нь шургуулга доторх дүүрэн баримттай хавтаснууд. Харин мэдээ нь уг баримт нь болох юм. Хэрвээ баримтууд ерөөгөөр дүүрэн тарчихсан байвал учир замбараа нь олдохгүй юм болно шүү дээ. Бас та баримтуудаа төрөл зүйлээр нь ангилаад хавтаснуудад хийчихсэн ч гэсэн хавтаснуудаа мөн ерөөгөөр нэг тараачихвал арай дээрдсэн ч мөн л замбараа муутай бах болно. Эсвэл баримтуудаа хавтаст хийлгвйгээр бүгдийг нь шургуулгандаа чихчихвэл хэр зэрэг байх бол? Тиймээс та өөрийн баримтуудаа (мэдээ) цэгцтэй байлгаж, төрөл зүйлээр нь хавтаслаад (категори), хавтаснуудаа мөн ангилан, хоорондоо холбоотой хэдийг нь нэг шургуулганд (секц) хийх хэрэгтэй.

Секц, категориудтай байхын бас нэг давуу тал нь тэдгээрт өөр өөр вебийн загвар оноож өгөх боломж юм. Ухаандаа “Шинэ мэдээ” гэсэн секц нь 2 баганаар мэдээгээ харуулдаг бөгөөд хажуудаа сайтын гишүүдийн нэвтрэх модуль, санал асуулгын модуль хоёртой хамт байдаг бол хуучин мэдээнүүд нь өөр загварын дагуу 4 баганаар мэдээгээ гаргадаг байх жишээтэй. Нэг секц нь шаргал дэвсгэртэй байдаг бол нэг нь ягаан дэвсгэртэй байдаг ч юм уу.. Хооронд нь ялгахад илүү хялбар болох юм.

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

“Статик мэдээ” гэсэн ойлголттой та гарын авлага дээр цөөнгүй таарч байсан байх. ТАУС-д Секц юмуу категорид багтааггүй мэдээг ингэж нэрлэдэг. Эдгээр нь нэгэнт сайтын стандарт мэдээний бүтцэд багтааггүй учраас бие даасан хэдэн параграф мэдээлэл, текст болон зураг гэж ойлгож болно. Ийм бие даасан статик агуулгыг нүүр хуудсан дээр оруулах боломжгүйгээс гадна дээрх шиг тус бүрт нь вебийн загвар оноож өгөх боломжгүй байдаг.

Ингээд та өөрийнхөө сайтыг ямар зохион байгуулалттай байлгахыг хүсч байгаа талаараа бодох хэрэгтэй. Сайтынхаа секцүүдийг өөр өөр дизайнтай байлгахыг хүсч байгаа эсэх, хэдэн секц, хэдэн категорит мэдээллээ хуваах гэх мэт олон зүйлсийг урьдчилан төлөвлөх нь таны вебээ хийх явцыг хэд дахин хурдасгана шүү.

Дараагийн зөвлөгөө: [Сайтынхаа дизайныг тохируулах](#)

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

Сайтынхаа дизайныг тохируулах

Template буюу вебийн загварууд нь таны сайтын, эсвэл таны сайт доторх бие даасан секцүүдийн харагдах байдалыг тодорхойлдог. Хэрвээ та загварын удирдлагын хэсэгт удирдах самбарын толгойн цэсээс Site > Template Manager > Site Templates гэсэн хаягийн дагуу орох юм бол таны вебсайт дээр одоогоор суулгагдчихсан байгаа хэд хэдэн загварын жагсаалтыг орж харах болно. Эдгээрийн аль нэгнийх нь нэрийн урд тэмдэглээд баруун дээд талын хэрэгслийн мөрөн дэх “default” товчыг даран загварыг солих боломжтой. Үүнийхээ дараа веб сайт руугаа ороод өнгө загвар нь хэрхэн өөрчлөгдснийг хараарай.

Вебийн загвар гэж юу вэ? Энэ нь таны сайтын дизайны талаарх мэдээллийг агуулсан хэд хэдэн файлуудын цогц юм. Эдгээрийн дундаас хамгийн гол файл нь хүснэгт, таны лого гэх мэтийн загварыг тодорхойлогч html код, динамик элементүүдэд зориулсан php кодыг агуулсан “index.php” файл юм. Дараагийн чухал файл нь сайтын элементүүдийн ашиглах фонтыг, өнгө, хүрээ гэх мэтийг тодорхойлдог style sheet буюу .css файл мөн.

Та интернэтээс үнэгүй загварууд татаж аван суулгах боломжтой. Нэг шинэ загвар л таны сайтыг цоо шинэ юм шиг харагдуулна шүү дээ. ТАУС-ын хамгийн сайхан тал нь энэ л юм уу даа. Гэхдээ та интернэтээс хайх явцдаа хамгийн гоё загварууд нь үнэтэй, жаахан онцгүйнууд нь үнэгүй байгааг анзаарах байх. Мэдээж тэр үнэтэй аватаруудыг үнэгүй олох аргууд бий л дээ. Гэхдээ энэ нь хууль бус учраас энд бичихгүй :-). Google.com дээрээс “joomla template” гээд хайхад олон зуун сайт гарч ирэх болов уу. Тэдгээр үнэгүй сайтуудын дундаас хамгийн чанартай хэд нь бидний үзэж байгаагаар:

<http://www.joomlaos.de/>


<http://www.mambohut.com/>

<http://www.joomlateam.com/>

Дээрх сайтууд дээрх үнэгүй загварууд нь мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн, чанартай загварууд учраас таны хэрэгцээг хангаж чадна гэж найдаж байна.

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

Веб хуудасны үндсэн байршлууд



Стандарт англи нэршлээр нь вебсайтын үндсэн блокуудыг дээр нэрлэсэн байгааг бид харж байна. Энэхүү блокуудад бид төрөл бүрийн мэдээлэл оруулан веб сайтын загвар үзэмжийг тодорхойлдог билээ. Улбар шар өнгөтэй блокууд бол дотор нь хүснэгтийн нүднүүд оруулах боломжтой байршлууд болно. Эдгээр улбар шар “байршлууд” дотор хэдэн ч модуль байршуулж болох бөгөөд нэмж хасах нь чөлөөтэй. Ухаандаа энэний дээд хэсэгт байгаа “Top” байршилд та хайлтийн модуль, он сар өдөр гаргадаг модуль хоёрыг байршуулаад, “Left” буюу зүүн талын байршилын блокт цэс (меню), гишүүдийн нэвтрэх модуль хоёрыг байршуулж болно шүү дээ.

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

“Banner” гэсэн ногоон блок-т нэг бол реклам сурталчилгаа, нэг бол өөрийн сайтын зохиогчийн эрхийн мэдээлэл, хэрэглээний болзол тэргүүтнийг оруулдаг. Header.jpg гэсэн цэнхэр блок дээр таны сайтын лого орж ирнэ. “Body” гэсэн ягаан блок-т харин үндсэн мэдээ, мэдээллүүд ордог билээ.

Вебийн загвар гэдэг маань үндсэндээ нэгдүгээрт эдгээр байршлуудыг хаана хаана нь орохыг зааж өгсөн, хоёрдугаарт хуудсын хэрэглэх style sheet-ийг тодорхойлсон хэсэг код билээ.

Style sheet гэдэг маань хуудсан дээрх текстийн ашиглах фонт, өнгө, хуудсан дээр зураг хөрөг байвал тэдгээрийн хүрээний өргөн тэргүүтнийг зааж өгдөг юм. Доорх веб-д зочилж түгээмэл хэрэглэгддэг style sheet-ийн кодуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч болно:

http://www.mamboos.de/Mambo_CSS_Guide/

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө

Хэрвээ та интернэтээс бэлэн вебийн загвар хуулж аван өөрийн сайтдаа ашиглахын оронд өөрөө сайтынхаа загварыг хийхийг хвсч байвал эндээс ТАУС-ын (Joomla-гийн) загвар хэрхэн хийх хичээлийг олж уншиж болно:

http://www.absalom.biz/tutorials/Mambo_Template_Tutorial.html

Загвараа Macromedia Dreamweaver программ дээр хийх бол www.mambosolutions.com/dw_tutorial/ дээр чухам үүнд зориулсан хичээл бий. Эдгээр нь мэдээж бүгд Англи хэл дээр байгаа. Вебийн загвар хийх нь нэлээн ахисан твшний хэрэглэгчдийн хийх зүйл бөгөөд бид энэхүү гарын авлагаа энгийн хэрэглэгчдэд зориулан гаргаж байгаа тул эдгээр хичээлүүдийг орчуулаагч юм.

Одоо бүгдээрээ сайтынхаа блокуудын байршлыг вебийн загвар ашиглан заагаад өгчихсөн болохоор дараагийн ээлжинд эдгээр блокууддаа хэдэн модуль нэмцгээе.

Дараагийн зөвлөгөө: [Модуль, компонент, мамбот](#)

Арван хоёрдугаар хэсэг: Зөвлөгөө**Модуль, компонент, мамбот**

ТАУС бол цаашид өргөжих бүрэн боломжтой байхаар хийгдсэн юм. Өөртэй нь хамт суулгагддаг олон олон бүрэлдэхүүнүүд дээр та бидэнд интернэтээс татаж аван суулгах боломжтой олон зуун нэмэлт бүрэлдэхүүнүүд бэлэн бий. Үүнд хамгийн гол бүрэлдэхүүн хэсгүүд болох Модуль, компонент, мамбот 3-ын талаар сайтар ойлгох нь чухал:

Модуль гэдэг нь таны сайтын мэдээллийг гаргаж харуулах үүрэгтэй энгийн нэмэлт программ юм. Сайтын цэс бол модуль. Хэрэглэгчийн санал асуулга - модуль. Гишүүдийн нэвтрэх талбар бас л модуль. Модуль нь веб хуудсын байршлуудад (“блокуудад”) оноогдож өгөх бөгөөд таны хуудас дахь өөрийн оноогдсон блок дээрээ гарч ирнэ.

Компонент бол бие даасан программ. Тэд ТАУС-ын удирдлагад нэмэлт боломжуудыг бий болгодог. Тэгэхээр та ТАУС сайтдаа нэмэлт боломжуудыг (функцуудыг) суулгая гэвэл модуль, компонент хоёрыг хоёуланг нь суулгаж таарна гэсэн үг. Шинэ компонент нэмснийхээ дараа та түүнийг компонент удирдах хэсгээс харж, тохируулах боломжтой болно.

Мамбот гэдэг нь харин жижиг, мэдээллийг сайт дээр гарч харагдахаас нь өмнө “барьж авч” өөрчлөх зорилго бүхий функц юм. ТАУС-тай хамт хэд хэдэн чухал мамбот суусан байгаа. Тухайлбал mosimage мамбот нь {mosimage} заагчуудыг html-ийн img заагч болгон өөрчлөх үүрэгтэй байх жишээтэй. Эдгээр нь өдөр тутмын үйл ажиллагаанд модуль, компонент хоёроос илүү бага гарч ирнэ.

Add-On гэдэг нь ТАУС-тай хамт суугаагүй төрөл бүрийн жижиг програмууд юм. Тэдгээр нь ихэнхдээ модуль, компонент хоёрын хослол байна. Add-On татаж авах хамгийн эхний сайт бол <http://developer.joomla.org/>.

За ингээд амжилт хүсье!